



**НИЙСЛЭЛИЙН СҮХБААТАР ДҮҮРГИЙН 1 ДҮГЭЭР
ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ БАЙРЛАХ ЭМГЭГ
СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН “ЛАВЛАГАА
ЛАБОРАТОРИ”-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ
БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Улаанбаатар хот
2019

ЭМГЭГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН "ЛАВЛАГАА ЛАБОРАТОРИ"-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН (БОТБУ)

БОТБУ-ний тайланг хүлээн авсан: Эмгэг Судлалын Үндэсний Төв

ЗАХИРАЛ: *Г. Уянга* / Г.Уянга /



БОТБУ-ний тайланг боловсруулсан: "ГРИЙН ХАРБОР" ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: *Б.Хосбаяр* /Б.Хосбаяр /



АГУУЛГА

ОРШИЛ	4
БҮЛЭГ 1 ТӨСЛИЙН ТАНИЦЛУУЛГА БОЛОН СУУРЬ НӨХЦӨЛ	5
1.1 ТӨСЛИЙН ТАНИЦЛУУЛГА.....	5
1.1.1 Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн үйл ажиллагаа:.....	5
1.1.2 Төслийн талаарх мэдээлэл	5
1.1.3 Төслийн байршил	5
1.1.4 Үндсэн агуулга	6
1.2 Эмгэг судлалын лавлагаа лабораторийн тоног төхөөрөмж.....	6
1.3 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АЖИЛЛАХ ХҮЧИН ЧАДАЛ	8
1.3.1 Бүтэц зохион байгуулалт	8
1.3.2 Ажиллах хүч.....	9
1.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ	10
1.4.1 Аюултай хог хаягдал	10
1.4.2 Энгийн хог хаягдал.....	10
БҮЛЭГ 2 БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ.....	12
2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ.....	12
2.2 ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ.....	13
2.3 АГААРЫН ЧАНАР	15
2.3.1 Судлагдсан байдал.....	15
2.3.2 Улаанбаатар хотын агаарын чанар.....	16
2.4 ГАЗРЫН ГАДАРГЫН ОНЦЛОГ, ГЕОМОРФОЛОГИ.....	20
2.4.1 ГАЗРЫН ГАДАРГЫН ОНЦЛОГ	20
2.4.2 ГЕОМОРФОЛОГИ	22
2.5 ГАДАРГЫН УС	22
2.6 ГАЗРЫН ДООРХ УС.....	25
2.7 ХӨРСӨН БҮРХЭВЧ	29
2.7.1 Хөрсөн бүрхэвч, хэв шинж.....	29
2.7.2 Судалгааны аргазүй	29
2.7.3 Хөрсний морфологи шинж чанар.....	29
2.7.4 Хөрсний эвдрэл, бохирдол.....	31
2.8 УРГАМЛАН БҮРХЭВЧ	31
2.8.1 Ургамалжилтын өнөөгийн төлөв байдал.....	32
2.9 АМЬТАНЫ АЙМАГ.....	32
2.9.1 Улаанбаатар хот орчмны амьтны аймгийн өнөөгийн төлөв байдал.....	32
2.10 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС	37
2.10.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал.....	37
2.10.2 Судалгааны бүс нутаг дахь тусгай хамгаалаттай газар нутаг	38
2.11 БАЙГАЛЬ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВ	40
2.11.1 Хууль, эрхзүй	40
2.11.2 Улаанбаатар хот ормын археологийн судалгаа.....	40
БҮЛЭГ 3 НИЙМГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	42
3.1 НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ	42
3.2 ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВӨЛ БАЙДАЛ.....	42
3.3 НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ	43
3.3.1 Хүн ам, айл өрх.....	43
3.3.2 Хүн амын хөдөлмөр эрхлэлт	43
3.3.3 Боловсрол	44
3.3.4 Эрүүл мэнд.....	46
3.3.5 Гэмт хэрэг	48

3.3.6	Хөдөө аж ахуй.....	49
3.3.7	Аж үйлдвэр	50
БҮЛЭГ 4 ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮД.....		51
4.1	ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД.....	51
4.1.1	Хөрс, газрын гадаргад үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	51
4.1.2	Хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	51
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....		52

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1-1	Талбайн солбицол	6
Хүснэгт 1-2	Лавлага лабораторийн тоног төхөөрөмжүүд	7
Хүснэгт 2-1	Туул голын хөндийн морфологийн үндсэн элемент	22
Хүснэгт 2-2	Олон жилийн дундаж урсац.....	23
Хүснэгт 2-3	Хур борооны үерийн их урсац.....	24
Хүснэгт 2-4	Гол мөрний хамгийн бага урсац.....	24
Хүснэгт 2-5	Туул голын дагуух усны чанар.....	25
Хүснэгт 2-6	Улаанбаатар орчмын газар доорх усны бүрдэл.....	26
Хүснэгт 2-7	Зонхилон тархсан хөрсний хэв шинж ба төрөл	29
Хүснэгт 2-8	Хөрсний химийн үндсэн шинж.....	30
Хүснэгт 2-9	Хөрсний механик бүрэлдэхүүн	30
Хүснэгт 2-10	Улаанбаатар хот орчмын ургамлан нөмрөгийн нөөц ба даац	32
Хүснэгт 2-11	Хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн жагсаалт.....	34
Хүснэгт 2-12	Улаанбаатар хот орчмын хөхтөн амьтаны зүйлийн жагсаалт	36
Хүснэгт 3-1	Хүн амын үзүүлэлтүүд.....	43
Хүснэгт 3-2	Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт	43
Хүснэгт 3-3	Халдварт өвчний гаралт	47
Хүснэгт 3-4	Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр	49
Хүснэгт 3-5	Малын тоо толгой, төрлөөр	50

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 2-1	Улаанбаатар хотын олон жилийн дундаж агаарын температур.....	13
График 2-2	Салхины чиглэл ба савхигүй байх давтагдал, дундаж хурд.....	14
График 2-3	Улаанбаатар хотын хур тунадасны хэмжээ.....	15
График 2-4	Хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2017-2018 он	17
График 2-5	Азотын давхар ислийн сарын дундаж агууламж, 2017-2018 он	18
График 2-6	Том ширхэглэгт тоосонцын сарын дундаж агууламж, 2014-2018 он	19
График 2-7	Жижиг ширхэглэгт тоосонцын сарын дундаж агууламж, 2014-2018 он.....	19
График 3-1	СӨБ-р хамрагдагчид, төрийн өмчөөр	45
График 3-2	Ерөнхий боловсролын сургуулийн үзүүлэлт	46
График 3-3	Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил, хүйсээр.....	46
График 3-4	Халдварт өвчний гаралт.....	48

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1-1	Эмгэг судлалын үндэсний төв	6
Зураг 1-2	Лавлага лабораторийн тоног төхөөрөмжүүд	7
Зураг 1-3	Эмгэг судлалын үндэсний төвийн хамт олон	8
Зураг 1-4	Дотоод менежмент бүтэц	9
Зураг 1-5	Ажлын байр	10
Зураг 1-6	Хог хаягдлыг түр ангилан хадгалах сав.....	11

Зураг 2-1 Улаанбаатар хотын агаарын бохирдлын байдал	16
Зураг 2-2 Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах суурин харуулуудын байршил	17
Зураг 2-3 Улаанбаатар хот, төвийн бүсийн орчимд тархаасан хөрсөн бүрхэвч	29
Зураг 2-4 Монгол орчны ургамал - газарзүйн тойрог	31
Зураг 2-5 Хот суурин газарт түгээмэл тархсан шавьж.....	33
Зураг 2-6 Хот суурин газарт түгээмэл тархсан шувууд.....	35
Зураг 2-7 Тусгай хамгаалаттай Богдхан уул	40
Зураг 3-1 Сүхбаатар дүүргийн төв байр.....	42
Зураг 3-2 Цэцэрлэгийн тоо, жил, төрлөөр	44

СХЕМИЙН ЖАГСААЛТ

Схем 2-1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал ба зориулалт.....	38
---	----

ОРШИЛ

Эрүүл мэндийн яамны харьяа "Эмгэг судлалын үндэсний төв" нь Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Эрүүл мэндийн сургалт, судалгаа болон өөрийн гистологи лабораторид эмгэг эд эсийн судалгаа, оношилгоог улсын хэмжээнд явуулдаг байгууллага билээ. Уг төв нь эмгэг судлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг байнга сайжруулж, олон улсын түвшинд хүргэх зорилготойгоор ажиллаж байна. Тус төвийн Эмгэг судлалын лавлагаа лабораторийн байгаль орчны төлөв байдлын үнэлгээг байгаль орчны үнэлгээ, судалгааны "Грийн Харбор" компани хийж гүйцэтгэв. Энэхүү төлөв байдлын үнэлгээнд байгаль орчны бүрэлдэхүүн болон нийгэм эдийн засгийн өнөөгийн түвшин, байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийг тодорхойлсон юм.

1 БҮЛЭГ ТӨСЛИЙН ТАНИЦЛУУЛГА БОЛОН СУУРЬ НӨХЦӨЛ

1.1 ТӨСЛИЙН ТАНИЦЛУУЛГА

Хуучнаар БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1973 оны 438 тоот тогтоолоор Эрүүлийг хамгаалах яамны дэргэд Улсын Патоанатомийн Товчоог анх байгуулснаар Монгол улсад Эмгэг Судлалын Албаны хөгжил эхэлсэн байна.

Монгол улсын Засгийн газрын 2005 оны 41 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2005 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 20 дугаар тушаалаар Эмгэг Судлалын Төв болж зохион байгуулалтад орж, улмаар Эрүүл мэндийн сайдын 2012.12.20-ны өдрийн №429 тоот тушаалаар "Лавлагаа төв", мөн Эрүүл мэндийн сайдын 2013.11.12-ны өдрийн №424 тоот тушаалаар "Лавлагаа лаборатори" болон батлагдсанаар үйл ажиллагаа нь улам өргөжин эмгэг судлалын тусламж, үйлчилгээг үзүүлдэг.

1.1.1 Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн үйл ажиллагаа:

- Эмгэг бүтэц судлалын бүх түвшний (эрхтэн тогтолцоо, эд, эс, эсийн нэгж, молекулын) амьд ахуйн эд, эс судлалын (биопси, цитологи), цогцсын эмгэг судлалын (аутопси) оношилгоо, шинжилгээг хийдэг;
- Төгсөлтийн дараах сургалтуудыг зохион байгуулдаг Үүнд;
 - (1) Анатомийн эмгэг судлалын үндсэн мэргэшлийн 2 жилийн сургалт.
 - (2) Эсийн эмгэг судлаач эмчийн 6 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалт.
 - (3) Эд, эсийн лабораторийн техникчийн 3 сарын төрөлжсөн мэргэшлийн сургалт.
 - (4) Эд судлалын техникчийн мэргэжил дээшлүүлэх 1 сарын сургалт.
 - (5) Эмгэг судлалын туслах ажилтны 45 хоногийн сургалт.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг;

1.1.2 Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр:	"Эмгэг судлалын лавлагаа лаборатори"
Байгууллага нь:	Эмгэг Судлалын Үндэсний Төв
Улсын бүртгэлийн дугаар:	9070003081
Регистрийн дугаар:	9129367
Улсад бүртгүүлсэн огноо:	2012.08.20
Хаяг:	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, гудамж: Энхтайваны өргөн чөлөө 1
Утас:	976-11-311377
Факс:	976-11-313820

1.1.3 Төслийн байршил

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дугаар хорооны нутаг дэвсгэрт Эмгэг судлалын үндэсний төв нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 24 өдрийн 343 тоот тогтоолоор Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн

барилгын 2 дугаар давхарт 785.12 кв.метр талбайд үйл ажиллагаагаа явуулдаг. Тус төвийн талбайн солбицлыг Хүснэгт 1-1-д, байршлын Зургийг 1-1-д тус тус үзүүлэв.



Зураг 1-1 Эмгэг судлалын үндэсний төв

Хүснэгт 1-1 Талбайн солбицол

№	Уртраг	Өргөрөг	Цэгүүд	Урт
1	633681.69	5308876.93	1-2	16.81
2	643697.90	5308881.35	2-3	2.78
3	643700.63	5308881.90	3-4	10.97
4	643711.42	5308883.85	4-5	4.69
5	643715.58	5308881.69	5-6	52.68
6	643727.30	5308830.33	6-7	0.26
7	643727.04	5308830.27	7-8	6.45
8	643720.80	5308828.67	8-9	1.64
9	643719.19	5308828.31	9-10	14.35
10	643705.23	5308824.99	10-11	5.68
11	643699.64	5308824.01	11-12	10.09
12	643692.41	5308831.04	12-13	1.92
13	643691.12	5308832.46	13-1	45.46

1.1.4 Үндсэн агуулга

Эмгэг Судлалын Үндэсний Төвийн "Лавлагаа лаборатори" нь төрөлжсөн мэргэжлийн эмгэг судлалын онош, шинжилгээ явуулах, олон нийтэд хандсан эрүүл мэндийн сурталчилгаа болон мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулагдаг.

1.2 Эмгэг судлалын лавлагаа лабораторийн тоног төхөөрөмж

Эмгэг судлалын лавлагаа лаборатори нь эд судлал, эс судлал, иммуногистохими, экспресс гэсэн 4 төрлөөр шинжилгээ хийгддэг.

Эд судлалын лаборатори: Мэс заслын ба оношилгооны амьд сорьц, эдийн шинжилгээг дараах үе шаттайгаар хийдэг Үүнд:

- эдийн зүсмэг бэлтгэх
- эд бэхжүүлэх
- эдийг усгүйжүүлэх
- эдийн лааны тосон блок бэлтгэх
- эдийн бичил бэлдмэл бэлтгэх
- эдийн бичил бэлдмэлийг ердийн будгаар будах
- эмгэг судлаач эмчид хүлээлгэн өгөх

Хүснэгт 1-2 Лавлага лабораторийн тоног төхөөрөмжүүд

Д/А	Тоног төхөөрөмж	Тоо ширхэг	Тайлбар
1	Biobase - High quality fume hood FH(A)	1	Сорох шүүгээ бүхий лабораторийн хэсэгт эдийн зүсмэг бэлтгэх, бэхжүүлэх шинжилгээ хийх
2	Amcs - atr 140 automatic slide strainer	1	Бүрэн автомат аппаратаар эд усгүйжүүлэх дамжлага явагдах бөгөөд нэг удаад 300 кассет сорьц шинжлэх
3	Avtp 2500 vacuum tissue processor	1	
4	Tec 2800-T	1	Эдийн лааны тосон цутгамаг бэлтгэх, цутгах, халаах, хөргөх иж бүрэн автомат аппарат
5	Tec 2800-C	1	Нэг удаад 98 бэлдмэл будах хүчин чадалтай өөрөө будагч автомат аппаратаар эдийн бичил бэлдмэл будаж бэлтгэдэх
6	Tec 2800-M	1	
7	Amr 400 manual rotary microtome	1	Эдийн зүсмэг бэлтгэх хагас болон автомат 0-600 микрон хүртэл зүсэх хүчин чадалтай микротом аппарат
8	Aem 450 atomated microtome	1	
9	Бусад	-	

Дээрх тоног төхөөрөмжөөс гадна эд эс судлалын шинжилгээний лабораторид олон улсын стандартад нийцсэн Thermo Scientific компанид үйлдвэрлэсэн ердийн будаг болох эсийн бөөм будах 2 төрлийн гематоксилин, эсийн сийвэн, бусад элементийг будах 2 төрлийн эозин будаг хэрэглэж байна. Үүнд: Жилл болон Харрисон гематоксилин, оранж Ж, олон өнгийн будгийн холимог EA50, усан болон спиртэн суурьтай эозин 1-2%-ийн үрвалж бодисуудыг нээлттэй тендерээр сонгон шалгаруулдаг ба уг тендерт "Этемо" ХХК нь зохиох журам, шаардлагыг хангаж нийлүүлдэг байна.



Зураг 1-2 Лавлага лабораторийн тоног төхөөрөмжүүд

Эс судлалын лаборатори: нь эмэгтэйчүүдийн ба эмэгтэйчүүдийн бус эс судлалын шинжилгээг уламжлалт Папаниколау будгийн аргаар будаж бэлтгэх,

эсийн блок бэлтгэн энгийн будгийн арга грамм, гимз, Лейшман, Циль-нильсон зэрэг будгууд хэрэглэж онош тогтоох шинжилгээг явуулдаг.

1.3 БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, АЖИЛЛАХ ХҮЧИН ЧАДАЛ

1.3.1 Бүтэц зохион байгуулалт


Тус төвийн бүтэц зохион байгуулалт нь Чанарын алба, Санхүү, эдийн засгийн алба, Эмгэг судлалын тусламж үйлчилгээний алба, Эс судлалын эрт илрүүлгийн алба, Сургалт судалгаа, эрдэм шинжилгээ, гадаад харилцааны алба, Бодлого төлөвлөлтийн алба, Ёс зүйн салбар хороо, Эрдмийн зөвлөл гэсэн бүтцээр ажиллаж байна.



Зураг 1-3 Эмгэг судлалын үндэсний төвийн хамт олон

Тэргүүлэх чиглэл:

- Насанд хүрэгсэдийн эмгэг судлал
- Хүүхдийн эмгэг судлал
- Молекул патологийн шинжилгээ
- Экспресс шинжилгээ
- Зайн анагаах ухаан (зайн сургалт, зайн зөвлөгөөн)
- Зайн оношилгоо (Вишион Тек, Нанозүүмэр)



Зураг 1-4 Дотоод менежмент бүтэц

1.3.2 Ажиллах хүч

Эмгэг Судлалын Үндэсний Төв нь 2 зөвлөл, 6 албаны уялдаа холбоо бүхий нэгдмэл зохион байгуулалтыг ханган 4 зөвлөх эмч, 19 эмгэг судлаач эмч, 3 эс судлаач, 3 био-анагаахын технологич, 16 лабораторийн техникч, 2 туслах ажилтан болон бусад 14 ажилтнаас бүрдсэн нийт 59 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.



Зураг 1-5 Ажлын байр

Нэг жилд Эд судлалын үндэсний төвийн лаборатори нь дунджаар 39549-43230 хүний 90505-114102 эдийн блок шинжилгээ, эс судлалын лаборатори нь 18141-30301 хүний шинжилгээ хийгддэг.

1.4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

2017 оны 12 сарын 12-ны өдрийн Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын А/505 дугаарт тушаалаар "Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, боловсруулах, устгах заавар" –р гарсан байдаг.

1.4.1 Аюултай хог хаягдал

Эмнэлгийн хог хаягдал аюултай хог хаягдалд тооцогддог бөгөөд уг Эмгэг Судлалын Үндэсний Төвөөс дараах аюултай хог хаягдал гарна Үүнд;

- Хурц үзүүртэй, иртэй хог хаягдал – зүү тариур, өндөг цоологч, наалдцын шил, хутга, ампул, хуруу шил;
- Эмгэг хог хаягдал – эдийн шинжилгээний лааны тосон цутгамал, судалгаа шинжилгээнд ашигласан эд эс, биеийн хэсэг, тайрсан зүйлс;
- Химийн урвалж бодисын хог хаягдал - Лабораторийн хаягдал, уусгагч, Формальдегид, этилен оксид, шингэн агуулж байсан сав, өдрийн гэрэл, зай;

1.4.2 Энгийн хог хаягдал

Ажилчдын байрнаас тодорхой хэмжээгээр энгийн хог хаягдал гарна Үүнд;

- Ахуйн хог хаягдал – хаягдал хүнсний бүтээгдэхүүн, бусад;
- Дахивар нөөц хаягдал – хаягдал цаас, төмөр, шил, хуванцар, эм урвалжийн гадна талын сав баглаа боодол, нэг удаагийн зүүний хуванцар таглаа (бохирлогдоогүй);

Тус хог хаягдлыг "Элемент Медикал" ХХК -тай байгуулсан гэрээний дагуу зориулалтын тусгай техникээр авч явдаг байна. Хог хаягдлын ангилан ялган түр хадгалдаг байна доорх зурагт үзүүлэв.



Зураг 1-6 Хог хаягдлыг түр ангилан хадгалах сав

Химийн урвалж бодисын хаягдал:

Химийн урвалж бодис агуулах савнууд нь шингэн үлдэгдэл агуулж байж болзошгүй. Эдгээр сав, боодлыг санамсаргүй авч ашиглах магадлалтай. Иймд химийн урвалж бодисын хаягдлыг хаяхдаа доорх аргачлалыг мөрдөж ажиллах нь зүйтэй.

- ✓ Өөр өөр төрлийн химийн бодистой хог хаягдлыг хольж болохгүй.
- ✓ Химийн бодисын үлдэгдлийг цуглуулах савны 50 хувиас илүү дүүргэж болохгүй.
- ✓ Шинж чанар төрлөөс хамааруулан хортой, зэврэмтги, исэл, шатамхай, холимог, аюултай гэх мэт тохирох таних тэмдэг заавал байршуулж байх.
- ✓ Химийн бодисын хог хаягдал асгарч болзошгүй тул савыг шингэн цуглуулах тавиур дээр тавих.
- ✓ Зөөх, тээвэрлэх нөхцөлийг хангасан түгжээтэй, бат бөх багтаамжтай хүрэн өнгийн саванд хийх.

2 БҮЛЭГ БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

2.1 ФИЗИК ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ

Улаанбаатар хот Монгол орны физик газар зүйн мужлалтаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн хэсэгт, тухайлбал Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд шувтарга үзүүрт Туул голын өргөн хөндий, ай сав цутгал голуудын бэлчирт байрладаг. Улаанбаатар хот далайн төвшнөөс дээш 1,350 метр өндөрт Номхон далайгаас 1,600 орчим км алсад, Дэлхийн экватороос хойш 5,310 км, хойд туйлаас урагш 4690 км зайтай буюу дэлхийн хойд өргөргийн 47°55', зүүн уртрагийн 106°55' -ын солбицолд, дэлхийн цагийн 7 дугаар бүсэд оршиж байна. Улаанбаатар хот урдуураа Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг, баруунаар мөн аймгийн Алтанбулаг, Аргалант, Баянцогт баруун хойгуураа мөн аймгийн Батсүмбэр, зүүн хойгуур Батсүмбэр, Эрдэнэ сумтай хиллэнэ. Улаанбаатар хот нь эх газрын эрс тэс уур амьсгалын нөхцөл нь уулсын байрлал, тэдгээрийн хажуугийн зүг зовхисын байдал, хотгор гүдгэрийн ерөнхий төрхтэй уялдан хөрс, ургамлан нөмрөг, гадаргын ус, улирлын хөлдөлт гэсэлт, бичил уур амьсгал бүрэлдэн тогтох онцлог нөхцөлийг бүрдүүлдэг. Энэ нь ялангуяа уулсын ам хөндий, ах өвөр хажууд тодорхой ажиглагддаг. Уулсын ам хөндийнүүдээр урсах гол горхины ус нь ихэнх тохиолдолд адаг орчимдоо сэвсгэр хурдас доогуур шурган ордог боловч хур бороо элбэг үед түр зуур ил урсан Туул голд цутгадаг. Туул гол, түүний цутгал гол горхины үндсэн тэжээл нь зун, намрын хур борооны ус юм. Ийнхүү эх газрын эрс тэс уур амьсгалын нөлөөгөөр хур тунадас бага, жил хоногийн температурын ялгаа их бүс нутаг юм. Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны шувтрах үзүүр Асралт хайрхан (2,799 м) уулын өвөр талаар Богд хан уулын ар хормойд (дундаж өндөр нь 1,350 м) Туул голын сав газарт байрлах бөгөөд Чингэлтэй уул (1,949 м), Баянзүрх уул (1,834 м), Богдхан уул (2,256 м), Сонгинохайрхан уул (1,652 м) гэсэн уулсуудаар хүрээлэгдэж оршино. Нийслэл Улаанбаатар хотын барилгажсан ба барилгажих талбай нь далайн түвшнээс дээш 1,260-1,350 м өндөр, газрын гадаргуу нь бүхэлдээ хойд уулсаас Туул голын сав хөндий чиглэсэн налуугийн тогтолцоотой юм. Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хамгийн өндөр цэг нь Богдхан уулын ноён оргил Цэцээ гүн (2,256 м), хамгийн нам цэг нь Туул голын хөндийд орших Шувуун fabriкийн район (1,203 м) болно. Нийслэлийн эзэмшил нутаг дэвсгэрийн хилийн цэсийн хүрээнд нийт 470.5 мян.га эдэлбэр газар хамаарагдаж байгаагаас хотжилтод шууд хамаарагдах (1:10000-ны масштабтай зургийн хүрээнд) 55136 га талбайн газрын гадаргуугийн налуу, өндрийн байдалд Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ-ний дагуу экспертийн аргаар үнэлгээ өгөхөд:

- Тохиромжтой 25,272.3 га
- Хязгаарлагдсан тохиромжтой 10,331.5 га
- Тохиромжгүй 19,532.1 га газар¹

¹ Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тогтоол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага. Улаанбаатар хотын өнөөгийн байдлын судалгаа дүгнэлт I бодит

2.2 ЦАГ УУР, УУР АМЬСГАЛ

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний хүчин зүйлийн хам нөлөөгөөр цөлжилт, байгалийн гамшгийн давтагдал нэмэгдэх, усны нөөц биологийн элдэв зүйл хомстох, газрын чадавх доройтох явц ажиглагдаж улс орны нийгэм, эдийн засагт төдийгүй байгалийн нөхөн сэргээгдэх нөөцөд сөргөөр нөлөөлж байгаа билээ. Агаарын бохирдолд байгаль, цаг агаарын нөхцөл маш их нөлөөлдөг ба өөрөөр хэлбэл агаарын урсгал, температур, инверсийн өндөр, эрчимшилээс хамаарч агаарын чанар өөрчлөгддөг.

Бид цаг агаар, уур амьсгалын төлөв байдал, сарын дундаж үзүүлэлтийг тооцохын тулд цаг уурын хяналт шинжилгээний ажлын сүүлийн жилүүдийн материалаас агаарын температур, хур тунадас, салхины чиглэл, хурд, үзэгдлийн ажиглалтыг түүвэрлэн шугаман хандлагын аргаар тооцон Улаанбаатар хотын цаг агаарын жилийн болон хүйтний улирлын төлөв байдлыг тодорхойлов.




График 2-1 Улаанбаатар хотын олон жилийн дундаж агаарын температур

Улаанбаатар хотод сүүлийн 40 жилийн агаарын дундаж температур -0.7°C байна. Эдгээр жилүүдээс 1985, 1970, 1969, 1966 оны жилийн дундаж температур -2.0 -оос -3.5°C хүрсэн буюу хамгийн хүйтэн жилүүд байв. Харин 2007, 2008 онууд хамгийн дулаан буюу жилийн дундаж агаарын температур 1.0 - 2.0°C дулаан байлаа. Улаанбаатар хотын агаарын температурын сарын явцаас харахад 7 дугаар сар хамгийн дулаан байгаа бол 1 дүгээр сар хамгийн хүйтэн байдаг байна.

Салхи: Улаанбаатар хотын салхины горимыг тогтоохдоо хотын бүсэд байрших Улаанбаатар (Тахилт), Буянт-Ухаа, Их сургууль цаг уурын харуулын мэдээг түүвэрлэв авч ашиглав. Улаанбаатар хот орчимд жилийн салхины дундаж хурд 2.2 м/с байх бөгөөд өвлийн улиралд харьцангуй тогтуун 0.6 - 1.3 м/с, 4-5 дугаар сард хамгийн их 2.9 - 4.1 м/с байна. Салхигүй намуун байх тохиолдол өвлийн XII-II сард Улаанбаатар, Буянт-Ухаад 45.8 - 54.2% , хавар, зуны саруудад хамгийн бага 21.8 - 27.1% байдаг. Харин Улаанбаатар хотод агаарын бохирдол ихэсдэг өвлийн улиралд газрын гадарга хүчтэй хөрсний улмаас газар орчимд температурын урвуу хамаарал тогтож 300 - 800 метрийн зузаантай инверсийн үе давхарга удаан хугацаагаар оршин тогтсоноор агаар мандлын доод хэсэг газрын

гадарга орчимд салхигүй, тогтуун байдал ноёрхож, хэвтээ болон босоо чиглэлд агаарын хөдөлгөөн багасдаг онцгой нөлөө үүсдэг нь агаарын бохирдол сарних нөхцлийг бууруулдаг байгалийн онцлог үүсдэг байна.




График 2-2 Салхины чиглэл ба савхигүй байх давтагдал, дундаж хурд

Манай оронд өвлийн улиралд эсрэг циклон хүчтэй ноёлж байдаг учраас салхигүй намуун байхын зэрэгцээ эсрэг циклон дахь агаарын урсгалын дагуу ерөнхийдөө баруун, баруун хойд, хойд зүгийн салхи зонхилдог байна. Газрын гадарга орчмын салхины горим агаар мандлын ерөнхий орчил урсгалаас гадна тухайн нутаг дэвсгэрийн уул зүйн онцлог, цаг агаарын процесс, дэвсгэр гадаргын хотгор гүдгэр зэргээс хамаардаг.

Улаанбаатар хот орчимд салхины чиглэл хотын нутаг дэвсгэр бүрт өөр өөр байх ба сар, улирал, хоногоор ихээхэн ялгаатай. Хотын төв хэсгээр баруун, баруун хойд, хойд зүгийн салхи бараг ижил давтагдалттайгаар зонхилдог бол хотын баруун хэсгээр хойт зүгийн салхи зонхилж, өмнө зүгийн салхи нилээд ажиглагддаг байна. Хотын зүүн хэсэгт тухайлбал Улаанхуаранд хойд зүгийн салхи зонхилдог боловч зүүний салхи жил бүрийн 1, 2 дугаар сард зонхилох чиглэл болдог байна. Хүйтний улирлын саруудын салхины зүгийн давтагдлаас үзэхэд Буянт-Ухаа өртөөнд салхины зүг өмнөөс, Амгалан, Улаанбаатар өртөөдөд зүүн болон баруун, баруун хойд зүгийн салхи голчлон ажиглагдсан байна.

Хур тунадас: Улаанбаатар хот орчимд чийгийн хувьд манай орны хамгийн тохиромжтой дундаж хэмжээнд байдаг. Тухайлбал хот орчимд жилдээ 225-230мм хур тунадас ордоогийн 90-95% нь дулаан улиралд буюу ургамлын ургалтын хугацаанд орох ба үүний 60-75% нь зөвхөн зуны 3 сард /6-8 сард/ унана. Хур тунадасны өчүүхэн хэсэг болох 5-8% нь өвлийн улиралд цас хэлбэртэй орж дунджаар 5-10 см зузаан тогтвортой цасан бүрхүүл хот орчмын нутагт 11-3 сард хадгалагддаг.




График 2-3 Улаанбаатар хотын хур тунадасны хэмжээ

Олон жилд дунджаас жилийн 76 өдөр хур тунадастай байдаг. Үүнээс 38 өдөр нь бороотой, 37.6 өдөр цастай байдаг. 2-3 өдөр ширүүн мөндөр, 30-35 өдөр аянга цахилгаан цахилж, нэгж талбайд 5-6 удаа ниргэлттэй байдаг гэсэн судалгаа гарсан байна. Иймд агаар мандлын эдгээр үзэгдлийн давтагдал, тоо хэмжээтэй уялдуулан аюулт үзэгдлээс хамгаалах нь чухал юм.

2.3 АГААРЫН ЧАНАР

2.3.1 Судлагдсан байдал

Бидний хүрээлэн байгаа амьсгалах агаарт шууд хаягдсан, эсхүл физик, химийн урвалын дүнд шинээр үүсч бий болсон бохирдуулах бодисын агууламж нь агаарын чанарын стандартаас хэтрэхийг агаарын бохирдол гэдэг. Агаарын чанар нь тухайн нутаг дэвсгэрийн газарзүйн байршил, хөрсний гадаргын байдал, цаг агаар, уур амьсгалын онцлог, байгалийн үйл явц болон хүний үйл ажиллагааны улмаас өөрчлөгдөж байдаг онцлогтой.

Агаарын бохирдлыг үүсгэгч үндсэн түгээмэл бодисуудад азотын давхар исэл (NO_2), хүхэрлэг хий (SO_2), тоосонцор ($\text{PM}_{2.5}$, PM_{10}), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO) багтдаг.

Агаарын чанарыг хянах байнгын хяналт шинжилгээний дүнгээс харахад Улаанбаатар хотын агаарын бохирдлыг үүсгэж байгаа гол бохирдуулах бодисууд нь хүхэрлэг хий, тоос тоосонцор, азотын давхар исэл байдаг ба хүйтний улиралд эдгээр бохирдуулах бодисын агууламж нийт ажиглалтын 50 гаруй хувьд Агаарын чанарын MNS4585:2016 стандарт дахь хүлцэх хэм хэмжээнээс хэтэрдэг байна.



Зураг 2-1 Улаанбаатар хотын агаарын бохирдлын байдал

Эдгээр агаар, орчны бохирдлыг бууруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа ажлууд үр дүн багатайгаас хотын хүн ам, ялангуяа хүүхэд, өндөр настны дунд агаарын бохирдлоос шалтгаалсан амьсгалын замын өвчлөл улам ихэсч, эрүүл мэндэд нь ноцтой хохирол учруулж байна. Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, байгаль орчны тэнцлийг хангах, хүрээлэн байгаа агаарыг хамгаалах, бохирдохоос урьдчилан сэргийлэх, агаар бохирдуулах бодисын хаягдлыг бууруулж хяналт тавих зэрэг бодлогын арга хэмжээ авахаар Монгол улсын засгийн газар, Улсын Их Хурал, холбогдох яамд "Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", "Ногоон хөгжлийн бодлого", "Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад Монгол Улсын оруулах хувь нэмэр", "Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр" болон Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Агаарын тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмжийг үндэслэн "Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг боловсруулан байгаль орчны бодлого, төлөвлөлтөнд баримтлан ажиллаж байна.

2.3.2 Улаанбаатар хотын агаарын чанар

Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт агаарын чанарыг гэр хороолол, авто зам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд нийт 14 цэгт агаар бохирдуулах бодис болох хүхэрлэг хий (SO_2), азотын давхар исэл (NO_2), том ширхэглэгт тоосонцор (PM_{10}), нарийн ширхэглэгт тоосонцор ($\text{PM}_{2.5}$), нүүрстөрөгчийн дутуу исэл (CO)-ыг автомат болон автомат бус багажаар хэмжин тодорхойлж байна.

2017-2018 онуудад Улаанбаатар хотын төвийн 6 дүүрэгт Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа 10 харуул (УБ1-УБ11), Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газрын харьяа 4 харуул (Нисэх, Толгойт, Зурагт, Амгалан) ажилласан тоон мэдээг авч Зураг 2-1 үзүүлэв.



Зураг 2-2 Улаанбаатар хотын агаарын чанарыг хянах суурин харуулуудын байршил

Хүхэрлэг хий SO_2

Улаанбаатар хотын агаарын чанарын төлөв байдлыг хянаж буй харуулуудын 2016 оны дүнгээр хүхэрлэг хийн жилийн ерөнхий дундаж агууламж 40мкг/м^3 буюу Агаарын чанарын MNS4585:2016 стандарт дахь хүлцэх агууламж (цаашид АЧС дахь ХА гэх)-тай харьцуулахад 2 дахин их байна. Жилийн дунджийн хамгийн өндөр агууламж Зурагт орчимд 74мкг/м^3 буюу АЧС дахь ХА-аас 3.7 дахин их, Толгойт орчимд 60мкг/м^3 буюу АЧС дахь ХА-аас 3 дахин их, Амгалан орчимд 66мкг/м^3 буюу АЧС дахь ХА-аас 3.3 дахин их байсан байна.




График 2-4 Хүхэрлэг хийн сарын дундаж агууламж, 2017-2018 он

Азотын давхар исэл NO_2

Азотын давхар ислийн жилийн дунджийн хамгийн их агууламж автомашины хөдөлгөөн ихтэй төв автозамын дагуу байрладаг Баруун 4 зам (УБ-2), 13-р хороолол (УБ-4) харуулуудын орчимд хэмжигдсэн ба АЧС дахь ХА-аас давсан тохиолдлын тоо эдгээр харуулуудын орчимд хамгийн их байна.

Азотын давхар ислийн сарын дундаж агууламж Улаанбаатар хотын хэмжээнд зөвхөн 1 болон 12-р саруудад агаарын чанарын стандарт ХА-аас давж байгаа

боловч томоохон автозамуудын орчимд жилийн турш бохирдолтой байгаа нь хэмжилтийн дүнгээс харагдаж байдаг. Жишээлбэл Баруун 4 зам (УБ-2), 13-р хороолол (УБ-4) харуулуудын орчимд нийт хэмжилтийн 84-89%-д нь ХАаас давж бохирдсон тохиолдол илэрчээ. Азотын давхар ислийн сарын явцаас харахад хүйтний улиралд агууламж нь нэмэгддэг хэдий ч хүхэрлэг хийтэй харьцуулахад улирлаас хамаарсан хамаарал харьцангуй сул байгаа нь ажиглагдаж байна. Азотын давхар исэл автомашины дотоод шаталтын хөдөлгүүрийн хаягдал утаанаас болон хүйтний улиралд бүх төрлийн шаталтаас ялгарч байна.




График 2-5 Азотын давхар ислийн сарын дудаж агууламж, 2017-2018 он

Нүүрстөрөгчийн дутуу исэл CO

Нүүрстөрөгчийн дутуу ислийн сарын дунджийн хамгийн өндөр агууламж 1 болон 12 дугаар сард мөн л гэр хорооллын орчимд буюу Толгойт, Зурагт харуулуудын орчимд ажиглагдсан ба сарын дунджийн хамгийн их агууламж Зурагт орчимд 5,259 мкг/м³-д хүрсэн байна. Нүүрстөрөгчийн дутуу ислийн агууламж өвлийн улиралд галлагаа эхлэх үед буюу өглөө 7-9, орой 17-23 цагуудад агууламж ихэсдэг бол дулааны улиралд болон өдрийн цагаар багасдаг ерөнхий зүй тогтол байна. Угаарын хий нь бүх төрлийн түлшний дутуу шаталтын явцад үүсэх бөгөөд хатуу түлш шатаах галлагааны эхэн үед, дотоод шаталтат хөдөлгүүр доголдолтой байх үед илүү их ялгардаг ба орчны агаарт ихээр ялгарах үед хүний эрүүл мэндэд богино хугацаанд шууд нөлөөлдөг маш хортой хий юм.

PM₁₀ тоосонцор

Улирлын онцлогоос хамааран айл өрхийн түүхий нүүрс, түлшний шаталт болон тээврийн хэрэгслийн хөдөлгүүрээс гарах хаягдал утаа, ил задгай үнс, нүүрс, ахуйн хог хаягдал болон цаг агаар, хөрсний хуурайшилт, салхи шуурга ихтэй үед хөрс, автозамын сул шороо болон барилга, зам засвар зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагаанаас шалтгаалан газрын гадаргаас агаарт дэгдэх тоосонцор маш их болдог.

Улаанбаатар хотын агаар дахь PM₁₀ тоосонцрын агууламж нь Монгол улсны MNS4585:2016 стандарт хүлцэх агууламжаас 24 цагт 0.1 мг/м³ (нэг метр куб

агаарт 0.1 миллиграм) гэж заасан болон энэ хэмжээ 6,7,8 дугаар сараас бусад сард зөвшөөрөгдөх агууламжаас 1.1-8.4 дахин их байна.




График 2-6 Том ширхэглэгт тоосонцын сарын дундаж агууламж, 2014-2018 он

PM_{2.5} тоосонцор

Улаанбаатар хотод PM_{2.5} тоосонцрын агууламж нь сарын явцаас харахад хүйтний улиралд агаар дахь агууламж нь эрс өсч, дулааны улиралд буурдаг зүй тогтол ажиглагдаж байгаа нь PM₁₀ болон SO₂-той ижил зүй тогтолтой ба сарын дундаж агууламж жил бүрийн 4-9 дүгээр сард бага бусад сард зөвшөөрөгдөх агууламжаас 1.4-5.7 дахин их, хамгийн их хэмжээн нь Зурагт, Толгойт зэрэг томоохон гэр хорооллын орчимд хүйтний улиралд 12.4 дахин их хэмжигдсэн байна.




График 2-7 Жижиг ширхэглэгт тоосонцын сарын дундаж агууламж, 2014-2018 он

Монгол Улсын Засгийн газраас агаарын бохирдолыг буруулах нэг алхам хийсэн нь 2018 оны 2 сард 28 –ны өдрийн 62 дугаар тогтоолоор боловсруулаагүй нүүрсийг 2019 оны 5 дугаар сарын 15 –ны өдрөөс эхлэн хориглох шийдвэр гарсан нь агаарын бохирдолыг буруулахад эерэг нөлөөлөл үзүүлж байгааг дурдах нь зүйтэй.

2.4 ГАЗРЫН ГАДАРГЫН ОНЦЛОГ, ГЕОМОРФОЛОГИ

2.4.1 ГАЗРЫН ГАДАРГЫН ОНЦЛОГ

Улаанбаатар хот орчим нь Хангай-Хэнтийн синклиноори, Хангайхэнтийн түрбитит террейн, МонголАгнуурын атриат тогтолцоо зэрэг янз бүрийн нэрээр уншигчдад хүрсэн геологийн стрүктүрийн хэмжээнд байрших ба хэд хэдэн тектоникийн дэд террейнүүдээс тогтоно. Үүнд: хойноос урагш: Асралт хайрхан, Улаанбаатарын түрбидит террейнүүд болно. Эдгээр террейний хэмжээнд насны үндэслэл сул дээд рифейгээс эхлэн орчин үеийн дөрөвдөгч хүртэлх олон насны давхраажсан хурдас, мөн олон тооны интрузив бүрдлүүд тархсаныг энд хийгдсэн янз бүрийн зураглалын ажлуудад тусгагдсанаар товч тодорхойлолтыг нь оруулж өгөв. Тус төслийн талбайд тархсан давхраажсан хурдсуудын эзлэх хэмжээ харилцан адилгүй бөгөөд дунд-дээд палеозойн (Силиурээс карбон хүртэлх) насны хурдас хуримтлал ихээхэн талбайд илэрдэг бол зарим насны (неопротерозой, кембри, ордовикийн болон мезозо-кайозойн) хурдас хуримтлал нь маш бага талбайд илэрнэ.

Яргайт уул формац (NP3 ju): Үеллэг зарим үед анартай кварцит, фтанит, амфиболит, метаэлсжин, гантигжсан шохойн чулуу, бал чулуу агуулсан битумт шохойжингийн үе, үенцэртэй амфиболактинолитот, актинолит-эпидотот, амфиболэпидотот ногоон занар, цахир-анар-серицитэт, цахирхээрийн жоншт, биотит-хээрийн жонш-цахирт, биотит-анарт, гялтагнуурт занар, пироксент талст занар, ховроор дацит порфир, риодацит порфир, тэдгээрийн туф кристалокласт метатүф, бал чулуут занар, гнейс, мигматит, кварцит-амфиболт занарын флишүүдээс тогтох харьцангуй өндөр метаморфизмд орсон хурдасыг түүнд агуулагдах микрофитолитод үндэслэн неопротерозойн яргайт формацид ангилсан байдаг. Тус формаци нь төслийн талбайн зүүн-өмнөд хэсэгт Хэрлэн голын баруун эргээр харьцангуй багахан талбайд илрэх ба түүнийг Хэнтийн синклинорийн атриат суурийн цухуйцийн үлдэц хэмээн үздэг. Формацийн зузаан 2,300 м байдаг.

Чулуут формац (NP3ch): Үеллэг кварцит, метаэлсжингийн үеүүдтэй мусковитцахирт, хлоритцахирт, серицитэт, цахиурлаг серицит-мусковит-цахирт, гялтагнуурт занар, ховроор филлит, шохойжин, бичил занар гнейс зэргээс тогтох давхрагадасыг чулуут формацид анилсан байдаг. Тус формацийн чулуулаг нь яргайт формацтай хам орших ба маш хязгаарлагдмал тархалттай. Формацийн нийт зузаан 2,500 м.

Ширгүү формац (Cm2-O1sr): Элсжин, алевролит, занарын флишлэг хурдсаас голчлон тогтох зузаалгийг ширгүү формацид ангилжээ. Тус формаци нь хөх саарал, ногоовтор өнгөтэй жижиг ширхэгт шохойлог элсжин, алевролитын доод ба жижигдунд ширхэгт ногоон саарал, хөхөвтөр ногоон өнгийн элсжиний үетэй занаржсан алевролит, элсжин, занарын багц үеүдээс тус тус тогтоно. Стрүктүрийн хувьд Заг Хараагийн террейнд хамаарагдах тус формаци нь багахан талбайд эзэлдэг.

Хүрэн өндөр формац (O2hu): Асралт-Хайрханы дэд террейний зүүн хойд хэсэгт илрэх 3 мэмбэртэй зузаалгийг дунд ордовикийн хүрэн өндөр формацид ялгажээ. Формацийн доод мэмбэр нь метаандезит, метадолерит, андезитбазальт, амфибол-кварцат-занар, дацит, риодацит, түф-элсжин, дунд мэмбэр нь кварцит, элсжин, риодацитын үеүүд бүхий кварц-биотитсерицитэт, альбитат, хлориткварц-хээрийн жоншт ба эпидот-хлорит-амфиболт занараас, дээд мэмбэр нь метаандезит, түф андезит, тремолит-эпидотот, альбитат болон амфиболт занараас тус тус тогтоно. Формацийн нийт зузаан 2,850 м.

Силур: Улаанбаатар хотын баруун болон баруун-хойд хэсэгт Асралт-Хайрханы террейний структурийн хэмжээнд силурийн түвшинд ялгасан хурдас хуримтлал ихээхэн өргөн талбайд илэрнэ. Силурийн зузаалгуудыг өөр хоорондоо тектоникийн хил заагтай хүйн гол (S1hg) хушуут (S1hs), сөгнөгөрийн (S2sg) гэсэн хэд хэдэн формацид ангилжээ.

Горхи формац (D2-3gr): Улаанбаатар хотын орчимд Горхи уул, Туул, Тэрэлж, Минж голуудын сав газарт өргөн тархсан элсжин-занарын зузаалгийг В.А.Амантов нар 1 анх горхи формацид ангилсан бол хожим нь судлаачид түүнийг 2 мэмбэрт хуваажээ. Түүний доод мэмбэрийн зузаалагт хар-ногоон, хар-саарал, цайвар-ногоон өнгөтэй жижиг-дунд мөхлөгт хээрийн жонш-кварцат занаржсан-элсжин, шаварлаг занар, серицит-биотит-кварцат, серцитит-кварцат, кварц-хээрийн жоншит занаржсан алевролит голчлон, төмөр-марганцын ислээр баяжсан 5-100 м зузаан үеллэг текстүртэй кварцит, хас бага хэмжээгээр тус тус оролцоно. Дээд мэмбэрийн найрлаганд харногоон, хар-саарал, ногоон-саарал өнгөтэй, жижиг-дунд мөхлөгтэй аркозлаг найрлагатай элсжин, занаржсан элсжин, алевроэлсжин, алевролит, серицит-кварцат занар, гравелит, хүрэнүлаан өнгийн хас, төмөр-марганцын ислээр баяжсан үеллэг кварцитууд оролцоно. Формациудын доод болон дээд хил нь тодорхойгүй гол төлөв хагарлаар зааглагдсан байдаг.

Неоген (N2): Улаанбаатар хотын орчим, Зүүн наран, Гандантэгчилэн хийд, Тасганы овоо, Улаанхуаран, Хужир булан, Налайхын хотгорын баруун тал, Хөлийн голын хөндий, Сонгины "хаалга" (Туулын хөндийн нарийссан хэсгийг хэлнэ), Яармаг, Бөхөгийн гол, Хүйн голын хөндийнүүдэд илрэх улаан, улаан хүрэн өнгийн хурдас нь неогений түвшинд ялгагдана. Эдгээр хурдас сул барьцалдсан хөрзөн, элсжин, ихэвчилэн улаан хүрэн заримдаа цоохор өнгийн шавар зэргээс тогтоно. Хэмхдэсүүдийн найрлагад нь девон, карбоны настай метаалевролит, элсжин тохиолдох ба газрын гадаргад ихэвчилэн илрэхгүй боловч томоохон голын хөндий, хотгорын эрэг, мөргөцөгт дөрөвдөгчийн хурдасны доороос цухуйц үүсгэх нь олонтой. Неогены улаан хүрэн өнгийн хурдас нь палеозойн настай (доод-дунд девон, карбон) терриген чулуулаг ба ховроор доод цэрдийн терриген тунамал хурдас дээр өнцгийн болон давхарга зүйн үл нийцлэгээр хучдаг. Насны үндэслэлийн хувьд туулын хөндийд "сонгины хаалга" орчимд голын дэнжид илэрсэн улаан хүрэн өнгийн хурдаснаас олж илрүүлсэн хирсний ясны үлдэгдлээр (В.С.Домбровский 1926) плиоценд хамруулжээ.

2.4.2 ГЕОМОРФОЛОГИ

Улаанбаатар хотын нутаг дэвсгэр нь геоморфологийн нөхцлийн хувьд газрын гадаргуугийн хотгор, гүдгэрийн хэв шинжийн элэгдэл, идэгдэл-элэгдэл-хуримтлал болон хуримтлалын төрлийн ялгаж болно. Өндөр уулын бүсийн усан хагалбарын мужид зөвхөн газрын гадаргуугийн хотгор гүдгэрийн элэгдлийн хэв шинж зонхилж байхад намхан хэлхээ уул, бэсрэг толгодын хажуу ташлаг, энгэр, бэл, хормой болон гуу жалга, дэнжийн мөргөцгийн хэсэгт гадаргуугийн идэгдэл-элэгдэл-хуримтлалын төрөл давамгайлдаг. Харин Туул голын хөндийн ай сав болон хажуу жигүүрийн бэсрэг цутгал голуудын татамд газрын гадаргуугийн хуримтлалын төрөл, үйл явц зонхилдог. Улаанбаатар хотын нутаг дэвсгэр талбай болон зэргэлдээх бүсийн геоморфологийн нөхцлийн өвөрмөц онцлог, гадаргын хотгор гүдгэрийн динамик хэлбэлзлийг үнэлж тодорхойлоход Туул голын хөндийн морфологи нэлээд чухал үүрэгтэй байдаг. Туул голын хөндий нь морфологийн дараах үндсэн элементүүдтэй.

Хүснэгт 2-1 Туул голын хөндийн морфологийн үндсэн элемент

№	Татам дэнжийн нэр	Өндрийн хэмжээ, (м)	Нас
1	Нам татам	1.5	QIV
2	Өндөр татам	3	QIV
3	Татмын дээрх I дэнж (Амгалан)	5	QIV
4	Татмын дээрх II дэнж (Улаанбаатар)	8-9	QIII2
5	Татмын дээрх III дэнж (Зайсан)	11-12	QIII2
6	Татмын дээрх IV дэнж	15-16	QIII1

Гадаргуугийн тектоник-денудацийн гарал үүслийн төрөлд Богд уулын ар хажуугийн болон бусад голын хөндийн захын тектоник шилжилтийн хажуунууд, денудацийн төрөлд усан хагалбарын оройн гадарга ба хажуугийн дээд хэсэг, денудаци-хуримтлалын төрөлд усан хагалбарын хажуугийн дунд, доод хэсэг ба бэл-хормойн хурдас тархсан хэсгүүд, хуримтлалын төрөлд голуудын хөндий газрууд тус тус хамаарагдана².

2.5 ГАДАРГЫН УС

Улаанбаатар хот орчмын нутаг нь ус зүйн мужлалаар бол:

- Ус зүйн муж: Хойт мөсөн далайн ай сав
- Сав газар: Туул голын сав газарт багтана

Гадаргын усны сүлжээ сайн хөгжсөн, байнгын урсгалтай гол, горхи олон учир усзүйн хувьд сайн судлагдсан. Туул голын сав газарт гадаргын усны сүлжээний нягтшил буюу 1 км² талбайд ноогдох голын урт газар бүрт харилцан адилгүй ба 0-998 метрийн хооронд хэлбэлзэж, хамгийн их урсац бүрдэлт нь голын эхэн ба ус хагалбарын шугамын дагуух өндөр уулын бүсэд, хамгийн бага нь голын сав газрын адаг хэсэгт ажиглагдана. Сав газрын морфологийн нөхцөл харилцан адилгүйн улмаас голуудын урсацын хэмжээ дэд сав газар бүрт өөр өөр, урсацын модуль 0.2-7.0 л/сек·км²-ын хооронд хэлбэлзэнэ. Туул голын эхэн хэсэг, Тэрэлж,

² Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрүүдийн байгаль орчны өнөөгийн төлөв байдал, хотжилтын сөрөг нөлөөлөл, ус хорсдох ба бохирдох эрсдэл, III Боть

Тарнай голын эхэнд урсацын модуль 3.0-7.0 л/сек·км² хүрэх ба голын дунд хэсэгт Хөл, Гачуурт, Улиастай, Сэлбэ, Бөхөг, Гуна, Халиуч, Марс, Бад, Тарнай, Харбух голын савд 2.0-3.0 л/сек·км² орчим ба голын адаг хэсэгт урсацын модуль буурч 0.2- 1.0 л/ сек·км² болно.

Туул гол Хан Хэнтий нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2,000 метр өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намъяа, Нэргүй хэмээх хоёр голын уулзвараас эх авна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол горхи Туулд цутгана. Туул гол нь 6 дугаар эрэмбийн гол юм. Хортоны хуулийн голын тоо, урт, ус хурах талбайн харьцаа 4.2, 3.05, 5.58 тус тус байна. Энэ голын савд 1 дүгээр эрэмбийн гол 1,222; 2 дугаар эрэмбийн гол 320; 3 дугаар эрэмбийн гол 64; 4 дүгээр эрэмбийн гол 14, 5 дугаар эрэмбийн гол 4 байна. Хэнтий нурууны салбар уулсаас эх авсан Галттай, Сарьдагийн Хийд, Хаг, Хонгор, Зүүн Баян, Тэрэлж, Хөлийн гол, Улиастай, Сэлбэ, Харбух зэрэг гол горхи Туулд цутгана. Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч, урсацын алдагдал ихэснэ. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөрширээтэд 24.1 шоо м/с байна. Туул гол үерлэхдээ сав хөндийгөө дүүргэж, хуучин голдрилоо эргэн орж үндсэн голдрилоос алслан салаалдаг.

Олон жилийн дундаж урсац:

Туул голын жилийн дундаж урсац 5%-ийн хангамшилтай буюу элбэг устай жилд 59.1 м³/с хүрэх ба 97%-ийн хангамшилтай буюу бага устай жилд 6.00 м³/с болж буурна.

Хүснэгт 2-2 Олон жилийн дундаж урсац³

№	Гол мөрөн - Харуул	Ажигласа н хугацаа	Ус урсах		Олон жилийн дундаж урсац		Cv	Cs
			Талбай (км ²)	Дунда ж(м)	Q м ³ /с	h, мм		
1	Тэрэлж-Тэрэлж амралт	1971-2008	1,220.0	1,220.0	7.8	202.3	0.4	0.8
2	Сэлбэ-Санзай	1994-2008	32.0	1,620.0	0.1	120.0	0.7	1.4
3	Сэлбэ-Дамбадаржаа	1985-2008	188.0	1,510.0	0.4	70.5	0.6	1.3
4	Туул-Улаанбаатар	1990-2008	6,300	1,852	25.8	129.2	0.6	1.2

Улаанбаатар харуулын (1945-1995) урсацын материалаар Туул голын жилийн урсацыг тооцоход 1945-1957 онд ус багатай, 1958-1975 онд элбэг устай, 1976-1980 онд ус багатай, 1981-1995 онд ус элбэгтэй үеүд зонхилж иржээ.

Их урсац: Зуун жилд 1 удаа тохиох магадлалтай шар усны үер Туул голд 480, Тэрэлж голд 140 м³/стус тус хүрнэ. Жилийн хамгийн их урсац хур борооны үерийн үед ажиглагдах ба зуун жилд нэг удаа ажиглагдах магадлалтай их

³ Туул голын сав газрын УННМ төлөллөгөө

үерийн хамгийн их урсац Туул голд 1,850, Тэрэлж голд 822 тус тус м³/с хүрнэ (Хүснэгт 2-3).

Хүснэгт 2-3 Хур борооны үерийн их урсац

№	Гол-харуул	Янз бүрийн хангамшилтай өнгөрөлт, м ³ /сек					
		0.1%	1%	2%	5%	10%	15%
1	Тэрэлж-Тэрэлж амралт	3,076	1,850	1,480	1,120	800	500
2	Сэлбэ-Санзай	1,375	822	670	500	386	243
3	Сэлбэ-Дамбадаржаа	1,002	350	216	113	67.4	25.8
4	Туул-Улаанбаатар	-	1,536	1,238	947	689	447

Туул голын хамгийн их урсац хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед ажиглагдана. Хур борооны үер хаврын шар усны үерээс үргэлжлэх хугацаа, урсацын хэмжээгээр хэд дахин илүү байдаг. Олон өдөр үргэлжилсэн борооноос шалтгаалан удаан хугацаанд үертэй байх ба 7, 8 дугаар сард хамгийн их урсац ажиглагдана. Туул голын үерийн үргэлжлэх хугацаа дунджаар 14 хоног бөгөөд ихсэх нь 5 хоног, буурах нь 10 хоног байна. Туул голд болон түүний цутгал голд хамгийн их үер 1966, 1967, 1982 онд болжээ.

Бага урсац: Дулааны улирлын 30 хоногийн хамгийн бага урсац 50, 95, 97 хувийн хангамшилтай жилд Туул-Улаанбаатар хот орчимд 1.69; 0.67; 0.64; 1-р хөндлүүр ба Тэрэлж-Тэрэлж амралт орчимд 4.09-2.07; 3.55-1.60 м³/сек тус тус байна.

Хүснэгт 2-4 Гол мөрний хамгийн бага урсац

№	Гол-харуул	Янз бүрийн хангамшилтай өнгөрөлт, м ³ /сек					
		50%	75%	80%	90%	95%	97%
1	Туул-босгын гүүр	4.09	2.85	2.65	2.29	2.13	2.07
2	Тэрэлж -Тэрэлж	3.55	2.36	2.17	1.87	1.66	1.60
3	Туул-Улаанбаатар	1.69	1.05	0.95	0.76	0.67	0.64
4	Улиастай-Улиастай	1.09	0.75	0.70	0.60	0.56	0.54
5	Сэлбэ-Санзай	1.28	0.22	0.05	0.00	0.00	0.00
6	Сэлбэ-Дамбадаржаа	0.99	0.56	0.49	0.36	0.30	0.28

Усны бохирдол: Туул голын ус Тэрэлж голын орчим болон түүнээс дээшхи хэсэгт ямар нэг бохирдол бага байдаг. Харин Гачуурт орчмоос эхлэн аммонийн азотын агууламжийн бохирдлын шинж тэмдэг бага хэмжээгээр илэрч цаашид нэмэгдсээр ТЦБ-ын бохир ус нийлүүлснээс доош эрс нэмэгдэж зөвшөөрөгдөх агууламжаас 3,36-19,1 дахин давж тухайн бохирдлын хэмжээ Шувуун фабрик, Алтанбулаг хүртэл төдийлөн буурдаггүй байна. Нитритийн азотын (NO₂) бохирдлын шинж тэмдэг Сонсголонгын гүүр орчмоос ажиглагдаж Сонгино орчимд эрс нэмэгдэх боловч зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрдэггүй. Перманганатын исэлдэлт ТЦБ-ын бохир ус нийлэхээс өмнө харьцангуй бага байхад түүнээс доош агууламж нь нэмэгдэж үе үе зөвшөөрөгдөх хэмжээнээс давах хэмжээнд хүрдэг байна. Туул голын усан дахь биогений элементийн бохирдол Гачууртаас илэрч цаашид нэмэгдсээр ТЦБ-ын бохир ус нийлсний улмаас Сонгино орчимд хамгийн их хэмжээндээ хүрч цаашид аажмаар буурдаг.

Харин голын усан дахь микроэлементийн агууламж нийт голын хэмжээнд харьцангуй тогтвортой байдаг ч Сонгионы орчим үе үе нэмэгддэг. Ялангуяа цахиурын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 1,1-1,9 дахин их байсан. Туул голын усны бохирдлын жилийн доторхи өөрчлөлтийг авч үзвэл өвлийн гачиг үед буюу 12-2 сард хамгийн их хэмжээндээ хүрч хаврын шар усны үерийн үеэр буурч, зуны хур борооны үед хамгийн бага хэмжээндээ хүрдэг.

Туул голын усны чанар, бохирдлын үзүүлэлтийг усны чанарын индексийн зэрэглэлээр ангилан үзвэл Тэрэлж харуулын орчим болон түүнээс дээшхи хэсэг маш цэвэр, Туул - Гачуурт, Туул - Алтанбулаг, Туул - Өндөрширээт түүнээс доошхи хэсэг орчмын ус III зэргийн бага бохирдолттой ангилалд, Туул-Сонгиноос Шувуун фабрик хүртэлх хэсэг V зэргийн бохир усанд хамрагдаж байна. Энэ нь ТЦБ, Мах комбинатын хаягдал ус орсноос Сонгино орчим маш ихээр бохирдож II зэргээс V зэрэг хүртэл буурчээ.

Хүснэгт 2-5 Туул голын дагуух усны чанар

№	Үзүүлэлт	Босг ын гүүр	Босгын гүүрээс доош	Тэрэл ж	Тэрэлж ийн бэлчир	Туул гол УБ дээш 25 км	MNS 900:2005
Нэг. Үзүүлэлт							
1	Нарти, Na^+ мг/л	4.3	4.3	4.3	4.3	5.6	<200
2	Кали, K^+ мг/л	4.3	4.3	4.3	4.3	5.6	
3	Кальци, Ca^{2+} мг/л	9	9	9	9	10.0	<100
4	Магни, Mg^{2+}	1.8	1.8	2.4	1.8	1.8	<30
5	Сульфат, SO_4^{2-} мг/л	0.0	6	6	5.9	6.2	<500
6	Гидрокарбонат HCO_3^- мг/л	36.6	36.6	39.7	36.6	42.7	
7	Карбонат, CO_3^{2-} мг/л	0.0	0.0	0.0	0.0	0.0	
8	Хлорид Cl мг/л	1.8	1.8	1.8	1.8	1.8	<350
Хоёр. Физик шинж							
9	Ам, балл	-	-	-	-	-	<2
10	Өнгө, градус	-	-	-	-	-	<20 ⁰
11	Үнэр, балл	-	-	-	-	-	<2
12	pH	7.3	6.8	7	6.6	6.6	6.5-8.5
13	Цахилгаан дамжуулах $\mu/\text{см}$	62	64	71	62	64	
14	Хатуулаг, мг/дм ³	0.6	0.6	0.65	0.6	0.65	<7
15	Исэлдэн чанар мг/дм ³	4.21	4	2.4	4.48	4.16	
Гурав. Хүнд элементийн бохирдол							
16	Аммони (NH_4^+) мг/л	0	0.0	0.0	0.0	0	<1.5
17	Нитрат (NO_3^-) мг/л	0.8	0.8	0.8	0.8	0.8	<50
18	Нитрит (NO_2^-) мг/л	0.0	0.0	0.0	0.0	0.0	<1

Улаанбаатар хотын суурьшлын бүсээс дээших туул голын усны чанар харьцангуй сайн Монгол улсын Ундны усны стандарт болох MNS900:2005-ын шаардлагыг хангадаг байна.

2.6 ГАЗРЫН ДООРХ УС

Улаанбаатар хотын бүс нутгийн газрын доорх мужлалаар: Гидрогеологийн муж: Улирлын дунд тэжээлтэймуж, Монголын төв хэсгийн дэд мужад хамаарна. Туул

голын сав газрын хэмжээнд нүх сүвийн (бүрдэл), ан цавын (бүс) гэсэн үндсэн 2 төрлийн ус агуулагч бүрдэл тархсан ба ан цав-нүх сүвийн ус болох рашаан (Улаанбаатар, Ар, Өвөр Жанчивлан зэрэг нүүрс хүчилт хүйтэн рашаан) тархсан байдаг. Нүх сүвэрхэг дээд бүрдэл нь доод цэрд, неоген, дөрөвдөгчийн хурдас дотор, ан цавлаг бүс нь кембри, девон, карбоны настай тунамал, хувирмал, эсвэл юра, триасын түрмэл чулуулаг дотор тус тус бүрэлддэг. Туул голын сав газрын хэмжээнд тархсан хурдас чулуулгийн нас, литологийн төрлийг нэлээд ерөнхийлөн нэгтгэж, тэдгээрийг нүх сүвшилт зонхилсон, эсвэл ан цавшилт зонхилсон байдлаар нь ангилж, газрын доорх усны судлагдсан түвшин, хөдөлгөөний төрхийг харгалзан уг сав газрын хэмжээнд ус агуулагч нүх сүвэрхэг 6 бүрдэл, ус агуулагч ан цавлаг 2 бүсийг ялгав⁴. Эдгээр бүрдэл, бүсийн гидрогеологийн үндсэн өгөмжийг хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 2-6 Улаанбаатар орчмын газар доорх усны бүрдэл

№	Ус агуулагч бүрдэл	Өгөөмж ашигласан цооногийн тоо	Усны түвшин (бага-их), м	Түвшин бууралт (бага-их), м	Ундарга л/с	Усны эрдэсжилт г/л
1	Голоцений аллювийн бүрдэл	300	0.2-6.0	0.0-23.0	1.0-1-5.0	0.1-0.6
2	Туул хөндийг дагаж тархсан плейстоцений пролювийн пролюви – аллювийн бүрдэл	200	2.0-11.5	1.9-20.5	0.5-24.1	0.5-1.5
3	Цутгал голуудын хөндийг дагаж тархсан голоцений плейстоцений аллюви, пролювийн бүрдэл	270	0.2-12.0	2.0-40.0	0.5-8.0	0.3-1.3
4	Неогений хурдас дахь бүрдэл	20	19.37-119	2.0-40.0	0.5-3.8	0.5-1.6
5	Цэрдийн хурдас дахь бүрдэл	85	1.5-80.0	-	0.3-10.0	-
6	Триас-юрагийн давхраадаст чулуулаг дахь бүрдэл	45	3.0-33.0	1.0-15.0	1.0-1.3	0.2-0.3
7	Палеозойн тунамал, хувирмал бялхмаг чулуулаг дахь бүс	30	3.7-60.0	4.5-17.0	0.07-25	0.1-1.2
8	Түрмэл чулуулаг дахь бүс	115	8.6-26.5	2.7-5.1	0.1-4.3	0.1-0.7

Голоцений настай аллювийн хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг үе, бүрдэл

Голоцений үеийн (Орчин үеийн дөрөвдөгч-дээд дөрөвдөгчийн настай гэж 1990 оноос өмнөх ихэнх судалгааны материалд байдаг) настай аллювийн хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг бүрдлийг анхлан В.Н.Попов З.А.Лебедева нар 23.7-91.0 метр гүнтэй гидрогеологийн 6 цооногийг хуучин 1 дүгээр станцын орчим өрөмдсөн бөгөөд усны ундарга 2.1-10.2 л/с хооронд хэлбэлзэж, ерөнхийдөө усны харьцангуй их нөөцтэй байж болохыг тогтоосон.

⁴ 1933-2008 оны хооронд хийж байсан гидрогеологи, инженер-геологийн судалгааны тайлангуудыг иш үндэс болгов.

Голоцений настай аллювийн хурдас дахь ус агуулагч дээд үеийн ус нь химийн найрлагын хувьд ундны усны стандартын шаардлагыг хангадгийн дотор 0.1 г/л хүртэл эрдэсжилттэй, 0.9-5.5 мгэв/л хүртэл хатуулагтай, нитрат 1.1 мг/л хүртэл, төмөр 0.1 мг/л хүртэл агуулсан гидрокарбонатнати, гидрокарбонат-кальцийн найрлагатай, цэнгэг, зөөлөн ус байжээ.

Туулын хөндий дагаж тархсан плейстоцений настай аллюви, пролюви, аллюви-пролювийн хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг үе, бүрдэл

Уг бүрдэл нь Туул голын хөндийн баруун талаар 2 ба 3 дугаар дэнжийг үүсгэн тогтсон бөгөөд ус агуулагч хурдас нь хайрганцар-хайрга, элс, элсэнцэр, шавранцараас зонхилж тогтсон байна. Уг ус агуулсан хурдсын зузаан 19.5-33.5 м хооронд хэлбэлзэж, түүний доторх шавранцрын үе, мэшилийн зузаан 2.6-20 м хүрдэг байна. Плейстоцений настай аллюви хурдас дахь устай бүрдлийн ус заримдаа бага зэргийн даралттай байдаг.

Цутгал голуудын хөндий дагаж тархсан голоцени-плейстоцений настай аллюви, пролюви, пролюви-аллювийн хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг бүрдэл

Энэхүү бүрдэл нь Сэлбэ, Улиастай, Толгойт зэрэг цутгал голуудын адаг орчмын садаргыг бүрдүүлэн тархсан хушуу түүдсын хурдсаас тогтдог. Ус агуулагч хурдас нь тоосорхог, шаварлаг элс, элсэнцэр, шавранцар, мөлгөржөөгүй үйрмэгүүд болох сайрга, сайрганцар, заримдаа бул чулуу зэргээс бүрдэж байна. Энэхүү бүрдлийн ус 0.2-11.3 метрийн хоорондох гүнд илэрч байгаа боловч ихэвчлэн 4-6 м гүнд тааралддаг. Ус агуулсан хушуу түүгдсын энэхүү хурдсын зузаан 16-36 метр байна.

Неогений настай эх газрын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь усагуулагч нүх сүвэрхэг бүрдэл

Неогений настай эх газрын гаралтай, ихэвчлэн улаан өнгөтэй сэвсгэрдүү хурдас Туул голын сав газрын хэмжээнд дөрөвдөгчийн хурдсаар хучигдсан байдалтай хязгаарлагдмал тархсан байдаг. Ус агуулсан бүрдэл нь шавар, шавранцар доторх элс, хөрзөн, элсэнцэр, шавар дотор барьцалдсан хайрганцар, сайрганцраас тогтдог. Гандангийн дэнж дээр өрөмдсөн гидрогеологийн 138 дугаар цооногт газрын доорх ус 119 м гүнд нягтарсан хөрзөнгөөс гарч байсан бол мөн дэнж дээр өрөмдсөн 147 дугаар цооногт ус агуулсан 2 үе илэрсний 1 дүгээр үе нь 19.37м гүнээс, 2 дугаар үе нь 156 м гүнээс илэрч байжээ. Гандангийн дэнж дээр өрөмдсөн дээрх дурдаж буй 2 цооног, мөн 182 дугаар цооногт илэрсэн ус 87.2-130.0 м хүртэл даралттай байжээ. Амгалангийн орчим гаргасан 286 дугаар цооног 1.0-1.75 м зузаантай нимгэн үеийг нээсэн бөгөөд 17.4 м ба 36.75 м гүнээс 15.5 м хүртэл усны түвшин даралттай байж, 1.9-21.25 м даралт өгчээ. Энэ химийн найрлагаараа унд-ахуйн шаардлагад тохирохгүй ус илрэх нь харьцангуй элбэг байдаг.

Цэрдийн настай эх газар-нуурын гаралтай сэвсгэрдүү хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг бүрдэл

Энэ устай бүрдэл нь Туул голын сав газрын хилийн дотор хязгаарлагдмал тархалттай боловч Налайх дүүргийн ойр тойронд харьцангуй өргөн тархалттай. Налайхад өрөмдсөн нэлээд олон цооногоос артезийн өөрөө оргилдог ус гарч байсан. 1990-ээд оноос өмнө уурхайн ус шүүрүүлэлт, сүүлийн жилүүдэд газар тариаланд газрын доорх ус илүүтэйгээр ашиглах болсон, хуурайшилт эрчимтэй явагдаж газрын доорх усны тэжээгдэл хомсдох болсон зэрэг байгалийн өөрийнх нь болон хүний үйл ажиллагаатай холбоотойгоор газрын доорх усны түвшин буурч өөрөө оргилдог устай цооногийн тоо цөөрсөөр 2007 оны эцэст өөрөө оргилдог устай ганцхан цооног үлдсэн байв. Доод цэрдийн хурдас дахь ус агуулагч нүх сүвэрхэг бүрдлийн усны чанар унд-ахуйн усны стандартын шаардлагыг хатуулаг, эрдэсжилтээрээ хангадаггүй. Иймд энэ бүрдлийн усыг зөөлрүүлж, цэнгэгжүүлж хэрэглэх шаардлагатай.

Триас-Юрын настай хурдас дахь ус агуулагч давхраадаст нүх сүвэрхэг бүрдэл

Уг бүрдэл Туулын хөндийд Хустайн нурууны орчим, Харвахын (Хар бүхын) голын баруун хажуугийн намавтар уул, толгодын хэмжээнд тархсан. Хустайн нурууны орчимд тархсан юрын настай тунамал хурдас дахь ус агуулагч бүрдэлтэй холбогдон илэрдэг булгууд байдаг. Харвах (Хар бүхын) голын зүүн гар (баруун зүг) талын уул толгодыг хэрчсэн сайр хөндийд өрөмдсөн 50 дугаар цооногт 33 м гүнээс, 51, 52 дугаар цооногуудад илэрсэн триасын хурдас дахь ус агуулагч бүрдэл нь сайр хөндийн пролювийн хурдас дахь ус агуулагч бүрдэлтэй гидравлик холбоотойгоор нэгэн давхарга байдалтайгаар илэрч байжээ. Эдгээр цооногт илэрсэн усны түвшинг 1-15 м бууруулан шавхахад ундарга 1-1.3 л/с-ийн хооронд хэлбэлздэг байна.

Палеозойн настай тунамал, тунамал-хувирмал, бялхмал,бялхмал-хувирмал, хувирмал чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс

Уг бүс нь Туул голын сав газрыг хүрээлсэн уулсын хэмжээнд тархдаг. Устай энэ ан цавлаг бүс дотор өрөмдсөн гидрогеологийн цооногийн ундарга 0.07-25.0л/с-ийн хооронд хэлбэлзэж, усны найрлагын хувьд гидрокарбонат-натри, гидрокарбонат-натри-кальцийн төрлийн ус зонхилж, эрдэсжилт нь 0.1-1.06 г/л байжээ. Улаанбаатар хотын зүүн-хойт хэсгээр тархсан палеозойн тунамал чулуулаг дахь ан цавлаг тархаасан байдаг.

Түрмэл чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс

Туул голын сав газрын хэмжээнд Юрийн эриний настай түрмэл чулуулаг дахь ус агуулагч ан цавлаг бүс Богд уул, Горхи-Тэрэлж, Эрдэнэ сант, Угтаал цайдам зэрэг боржингийн томоохон массивууд болон бусад бага талбайтай массивын дотор тархсан. Богд уулын Зайсан толгойн аман дахь Урьдчилан хорих анги, Шарын эмнэлэг, Хөдөө аж ахуйн их сургуулийн орчимд өрөмдсөн хэд хэдэн цооногт бага ундарга бүхий газрын доорх ус илэрсний дотор Хөдөө аж ахуйн их сургуулийн орчимд гарган одоо хүртэл ашиглаж байна.

2.7 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Бидний судалгаанд Нийслэл хотын төвийн бүсэд орших Эмгэг судлалын үндэсний төв орчмын хөрсөн бүрхэвчийн өнөөгийн төлөв байдлыг тодорхойлоход тухайн орчны өмнөх судлагдсан мэдээ материалд тулгуурлан боловсруулав.

Улаанбаатар хотын хөрсний судалгааг Монгол улсын Шинжлэх Ухааны Академийн хөрсний судалгааны төвүүд болон Хөдөө Аж Ахуйн Их сургуулийн эрдэмтэн судлаачид нийлээд эрчимтэй судалж байсан. 2008 оноос хойш Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвчийн бохирдлын чиглэлээр нийлээд олон судалгаа хийгдсэн байдаг. Үүнд "Улаанбаатар хотын хөрсний бохирдлын суурь судалгаа. Газарзүйн хүрээлэн, 2010" судалгааны үр дүнгүүдээс харахад Улаанбаатар хотын хөрсөн бүрхэвч нь хүн амын төвлөрөл ихтэй газруудад ахуйн гаралтай органик бохирдол, техникийн ба үйлдвэрлэлийн гаралтай хүнд металлын бохирдолтой гэж тодорхойлсон байдаг.

2.7.1 Хөрсөн бүрхэвч, хэв шинж

Улаанбаатар хотын газрын гадарга 0-5% налуутай тэгшивтэр хөндий 5-30%-ийн налуутай толгод, уулс бүхий газрууд ихэнх талбайг хамарч байна. Улаанбаатар хот төвийн бүс орчимд зонхилон болон дагалдан тархах хөрснүүдийн хэв шинж ба төрлүүдийг доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2-7 Зонхилон тархсан хөрсний хэв шинж ба төрөл

Байгалийн бүс	Зонхилох хөрсний хэв шинж	Зонхилох хөрсний төрөл	Дагалдах хөрсний хэв шинж	Дагалдах хөрсний төрөл
Ердийн хээр	Хар хүрэн	Ердийн Хархүрэн сайргархаг, Чулуурхаг хархүрэн	Ойн Харшороон Аллювын	Ойн бараан Чулуухаг харшороон Аллювын бараан ба аллювын сайргархаг

2.7.2 Судалгааны аргазүй


- Хөрсний хил хязгаар тархалтыг харуулах үүднээс Dms-ulaanbaatar.opendata байр зүйн зургийг программ дээр тулгуурлан зураглал үйлдсэн.
- Хөрсний хими, физик шинж чанарын ерөнхий үзүүлэлтүүд суурь агууламжийг лабораторид тодорхойлсон.

2.7.3 Хөрсний морфологи шинж чанар

Төвийн бүс орчимд хөрсний үржил шимийн түвшин, эвдрэл, хөрсний хими, физик шинж чанарыг үзэхэд доорх төрлийн хөрсний морфологи хэв шинж илрэв.

❖ Хар хүрэн хөрс

Зураг 2-3 Улаанбаатар хот, төвийн бүсийн орчимд тархаасан хөрсөн бүрхэвч



Хөрсний физик, механик шинж чанар: Хар хүрэн хөрсөнд гол төлөв 2-3 үе тод ялгардаг:

А /0-20см/. хуурай, сийрэгдүү, дунд зэргийн бөөмөрхөг, элсэнцэр, жижиг сайр чулуу (2-3%), үл мэдэг наалдамхай, бага зэрэг уян харимхай, дунд зэргийн цөөн нүх сүвтэй, толбогүй, олон нарийн үндэстэй, үнэргүй, үе давхаргын шилжилт тод тэгшивтэр.

В /20-40 см/. чийгэрхүү, нягт, том бөөнцөр, элсэнцэр, жижиг сайр чулуу (5-10%), бага зэрэг наалдамхай, дунд зэрэг уян харимхай, цөөн жижиг нүх сүвтэй, толбогүй, цөөн нарийн үндэстэй, үнэргүй, үе давхаргын шилжилт жигд тод.

ВС /40-дээш см/. Цайвар саарал чийгэрхүү, сийрэгдүү, жижиг үйрмэг, элсэнцэр, дунд зэргийн хайрга чулуу (10-20%), дунд зэрэг наалдамхай, дунд зэрэг уян харимхай, дунд зэргийн жижиг нүх сүвтэй, толбогүй, маш цөөн нарийн үндэстэй, үнэргүй, үе давхаргын шилжилт тод долгиорхог.

Хүснэгт 2-8 Хөрсний химийн үндсэн шинж

Зүсэлтийн дугаар	Гүн, см	pH H ₂ O (1:2:5)	CaCO ₃ (%)	Ялзм аг (%)	EC25 dS/m	Хөдөлгөөнт, мг/100г	
						P205	K2O
Зүсэлт	Өнгө	7.94	1.82	0.436	0.1143	0.21	7.6

Хүснэгт 2-9 Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Гүн, см	Элс (2- 0.05мм)	Тоос (0.05-0.002мм)	Шавар (<0.002мм)
Зүсэлт	өнгө	68.7	20.5	10.8

Хөрсний чанарт элэгдэл, эвдрэлд тодорхой хэмжээгээр өртсөн хөрсний ялзмагийн агууламж бүсийн дунджаас бага зэрэг буурсан хэмжээнд, нимгэн


ялзмагт давхаргад шим тэжээлийн бодисоор баялаг, харин ул хөрсөнд шим тэжээлийн бодис дутмаг, элсэрхэг шавранцар механик бүрэлдэхүүнтэй буюу ерөнхийдөө уулын нимгэн хүрэн хөрсний хэв шинжийн бүсийн дунджийн агууламжтай байна.

2.7.4 Хөрсний эвдрэл, бохирдол

Нийслэлийн хэмжээнд хөрсний бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их байгаа ба хотын хэмжээнд химийн хорт бодис ялгаруулдаг 700 гаруй үйлдвэр, компани байгаа бөгөөд Улаанбаатар хотын хэмжээнд азот, цианит натри, хлор, бром зэрэг хүнд хортой элементүүд орон зайн хувьд хэлбэлзэлтэй байдгийг судалгаагаар тогтоосон байдаг. Нийслэлийн нутаг дэвсгэр дээр тоосгоны үйлдвэр 23, элс, хайргын үйлдвэр 32, арьс шир боловсруулах үйлдвэр 76, автомашин засварын газар/дугуй засвар, тосны худалдаа, сэлбэг худалдааны 314, асфальтын үйлдвэр 11, шатахуун түгээх газар, нефть хадгалах агуулах 166 тус тус үйл ажиллагаа явуулж байгаагаас үүдэлтэйгээр хотын хөрсний бохирдол сүүлийн жилүүдэд нэмэгдсээр байна.

2.8 УРГАМЛАН БҮРХЭВЧ

Улаанбаатар хот нь Хэнтийн нурууны өмнөд шувтарга, Монгол-Дагуурын ургамал-газар зүйн тойргийн хойд хэсэгт багтдаг. Хотын ургамалжилт ургамлын зүйлийн хувьд баялаг, содон сонин шинж төрхтэй. Эх газрын эрс тэс уур амьсгалыг төлөөлсөн бөгөөд далайн түвшинээс дээш (д.т.д) 1311,3 метрийн өндөрт оршдог. Ургамал ургах хугацаа 90-110 хоног хэмээн тооцогдох боловч ургамлын амьдралын хэлбэр, тэдгээрийн биологийн онцлогоос шалтгаалан янз бүр байдаг. Энд өндөр уул, ой хөвч, хээр тал хослон тогтсон онцлогтой.



Зураг 2-4 Монгол орчны ургамал - газарзүйн тойрог

Ботаникийн хүрээлэнгийн судлаач С.Жигжидсүрэнгийн тодорхойлсноор Улаанбаатар хот орчмын ургамлан нөмрөг нь 28145.2 га талбайг эзлэх бөгөөд үүнд: Өндөр уулын нуга 0.7%, Ойн 25.2%, Хээр 24.7%, Голын хөндий нуга 7.8%, Хужирлаг нуга 3.4%- ийг эзэлнэ гэж бичжээ.

Хүснэгт 2-10 Улаанбаатар хот орчмын ургамлан нөмрэгийн нөөц ба даац

№	Ургамалжилт ын Хэв шинж	Талбай га	Нийт талбайд эзлэх %	Аж ахуйн жилийн дундаж ургац ц/га	Нийт ургац тонн	Бэлчээрийн даац /хонин толгой/
1	Өндөр уулын нуга	2796.6	0.7	3.8	1069.9	-
2	Ой	95264.4	25.2	4.1	38769.7	-
3	Уулын нуга	28564.6	7.5	5.0	14294.3	25525.5
4	Уулын хээр	25661.2	6.8	3.8	9669.3	17266.6
5	Чулуусаг хээр	90409.1	23.8	2.4	22043.2	39362.9
6	Хээр	93818.9	24.7	2.1	19809.8	35374.6
7	Голын хөндийн чийгсэг нуга	2990.1	7.8	4.2	12348.4	22050.7
8	Хужир мараат нуга	13021.8	3.4	2.2	2878.6	5140.4
Бүгд	279026.8	100	3.2	120883.2	144720.7	144720.7

Ургамлан нөмрөгт хээрийн хэв шинж давамгайлах учир экологийн даацын хувьд тийм ч өндөр биш. Ургамлан нөмрэгийн 22.5% нь 35%-иас бага, хучлагагүй халцгай газрын эзлэх хэмжээ их байгаа нь хөрсний хуурайшилтыг нэмэгдүүлэх, салхи, усны элэгдэлд нэрвэгдэх магадлалыг ихэсгэх нөхцлийг бүрдүүлнэ. Хотын төвөөс хойшлох тусам шарилж, хамхуул зэрэг 3-4 зүйл ургамал тохиолдох бол урагш голын дагуух цэвэр усны хангамжийн байгууламж руу дөхөх тусам алаг цоог хялганы микроценоз тааралдаж улалж бүхий 10-12 зүйлийн бүрэлдэхүүнтэй эвслээр солигдоно. Ургамлын тусгаг бүрхэц урд хэсэгт 15-25 хувь, барилгын газар шорооны ажил хүчтэй нөлөөлж зулгарсан хэсэгт бараг нүцгэн, хойд хэсэг уруу 25 орчим хувийн тусгаг бүрхэцтэй. Гэхдээ бүрхэцийг намарын сүүл 10 сарын эхээр тогтоосон тул зуны дээд ургацын үетэй адилгүй юм.

2.8.1 Ургамалжилтын өнөөгийн төлөв байдал

Судалгааны талбай нь нийслэл хотын төвийн бүс, хүн ам, худалдаа үйлчилгээний төв ихээр төвлөрсөн газар учир үндсэн ургамалжилт нь унаган төрхөө алдаж зохиомлоор тарималжуулсан эсвэл орчны бохирдолд тэсвэртэй хүмүүнсэг зүйлүүд голчлон ургасан байна.

2.9 АМЬТАНЫ АЙМАГ

2.9.1 Улаанбаатар хот орчмын амьтны аймгийн өнөөгийн төлөв байдал

Улаанбаатар хотын экосистемийн амьтны аймаг нь байгалийн экосистемийнхээс эрс ялгаатай. Янз бүрийн шавьж, тагтаа, зэрэг амьтад амьдарч элдэв төрлийн өвчин үүсгэх, тараах сөрөг үр дагавартай. Улаанбаатар хотын экосистемийн хувьд Улаанбаатар хот, түүний орчмын шувууны экологи, практик холбогдол гэсэн илтгэлээс харахад (Ш.Болдбаатар, 1988, 1997) харьцангуй сайн

судлагдсан. Хот суурин газрын шувуудыг судлах нь хотын экологийн нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуй, хүн амын нягтрал, гоо зүйн хүмүүжил, цэцэрлэгжүүлэлт зэрэг олон зүйл асуудалтай уялдаатай байдаг. А.Болд (1990) Улаанбаатар хот ба түүний орчим нутагт 132 зүйл шувуу бүртгэж тэдгээрийн гарал үүсэл, тоо толгойг судалжээ. 1997 оны байдлаар Улаанбаатар хот, түүний орчим нутагт 14 багийн 204 зүйл шувуу бүртгэгджээ (Ш.Болдбаатар, 1997). Улаанбаатар хот орчмын хог хаях цэгүүд нь зарим зүйл шувуудын цуглах газар болсон. Хотод шувуу үүрлэх, орогнох өөр нэг орчин нөхцлийг байшин барилгын дээврийн хонгил бүрдүүлдэг. Хотын төв хэсгийн хуучин байшингийн дээврийн хонгилд их хэмжээний сангас, өндөгний хальс, өд ноолуур, хагд өвс, үхсэн шувууны сэг хуримтлагдаж янз бүрийн аалз хэлбэртэн, шавьж, арбовирус тээгч хачиг, бүүрэг үүрлэх нөхцөл болдог. Мөн байшингийн дээврийн хонгилд шувууны сангас хэт ихээр хуримтлагдан зузаарах нь дээвэр сууж хагарах шалтгаан болдог байна.

Сээр нуруугүй амьтад: Нийслэл Улаанбаатар хот орчимд шавьжийн зүйлийн баялагтай. Ялангуяа идэш тэжээлийн хувьд цэцгийн балаар хооллож буй зүйлүүд их тохиолдоно. Нийслэл орчмын Diptera – Хос далавчтан (ялаа), Hymenoptera – Хальсан далавчтан (хар шоргоолж), Lepidoptera – Хайрсан далавчтан (эрвээхэй), Coleoptera – Хатуу далавчтан (цох), Heteroptera – Хатуувтар далавчтан (бясаа), Orthoptera – Шулуун далавчтан (царцаа), Odonata – Соно зэрэг багуудын зүйлүүд түгээмэл тохиолддог⁵.

Монгол орны хэмжээнд сээр нуруугүй амьтдын талаарх бүс нутгийн болон дэд бүсийн хэмжээнд хийгдсэн, нийтлэгдсэн системтэй судалгаа цөөн бөгөөд ашиглах хэвлэмэл бүтээл хомс. Улс орны хэмжээнд зарим шинэ зүйлүүд бүртгэгдэж байгаа ч, өнөөг хүртэл олж тодорхойлсон зүйлүүдийн дотор эндемик болон, хамгаалах шаардлагатай зүйл байхгүй байна.



Зураг 2-5 Хот суурин газарт түгээмэл тархсан шавьж

Загас: Улаанбаатар хот орчим загас амьдрах боломжтой гол нь Туул гол бөгөөд туул голын сав газруудад түгээмэл тохиолддог зүйлүүдийг онцлон авч үзсэн болно.

⁵ МУИС-ББС. 2011. Монгол орны шавьжийн хамгааллын статусын асуудал ба өнөөгийн байдал (эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл). Улаанбаатар хот, Монгол улс.

Туул голын сав газрын 2-р дэд бүс (Туул-Тэрэлж харуулаас Туул-Зайсан харуул хүртэл) болон 3-р дэд бүс (Туул-Зайсан харуулаас Алтанбулагийн гүүр хүртэл)-д хамаарна. Туул голын сав газарт 10 овгийн 16 зүйл загас тохиолддог. Монгол орны загасны Улаан дансд Бүс нутгийн хэмжээнд бүх сугас *Leuciscus idus* "ховордож болзошгүй", зэвэг *Brachymystax lenok* "эмзэг", тул *Hucho taimen* "устаж болзошгүй", шивэр хадран *Thymallus arcticus* "ховордож болзошгүй" гэж үнэлэгдсэн байна⁶. Эдгээр загас нь голын сав газрын цэвэр тунгалаг байдлыг илтгэгч болдог онцлогтой. Туул голын Улаанбаатар хотоос дооших хэсэгт мөргийнхөн овгийн 5 зүйлийн загас зонхилж, ердийн цурхай, сахалт эрээлж, чимхүүр загас, цулбуурт, алгана зэрэг загас цөөн тоогоор тохиолдсон байдаг.

Хоёр нутагтан, мөлхөгчид : Улаанбаатар хот орчмын чийглэг, ус намгархаг амьдрах орчинд Монгол орны хэмжээнд өргөн тархалттай хоёр нутагтан болох монгол бах *Bufo raddei*, сибирийн мэлхий *Rana amurensis* түгээмэл тохиолддог. Эдгээр нь Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (IUCN)-ны шалгуураар Бүс нутгийн хэмжээнд "анхааралд өртөхөөргүй" гэж үнэлэгдсэн. Монгол бах болон сибирийн мэлхий нь олон янзын амьдрах орчинд нэлээд өргөн тархалттай тул тэдгээрийг ховордуулах шалтгаан нь мөн л төдий олон янз байдаг. Тухайлбал, амьдрах орчны доройтол, усны бохирдол, байгалийн нөөцийн олборлолт, гол нуур, булаг шандын татралт, ширгэлт зэрэг олон шалтгаанаас тоо толгой нь хомсдон, ховордох магадлалтай боловч эдгээр шалтгаанууд одоогоор энэ зүйлүүдийг ховордуулах хэмжээнд хүрээгүй гэж үзэж байна⁷.

Хүснэгт 2-11 Хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн жагсаалт

№	Латин нэр	Монгол нэр	Монгол улс (IUCN)	Олон улс (IUCN)	CITES	CMS
Баг:Сүүлгүй хоёр нутагтан - ANURA						
Бахын овог-Bufonidae						
1	<i>Bufo raddei</i>	Монгол бах	LC	LC		
Мэлхий овог- Radidae						
2	<i>Rana amurensis</i>	Сибир мэлхий	LC	LC		
Баг:Хайрстан - SQUAMATA						
Жинхэнэ гүрвэлийн овог-Lacertidae						
3	<i>Eremias argus</i>	Монгол гүрвэл	NE	LC		
4	<i>Zootoca vivipara</i>	Зулзагалагч гүрвэл	LC	LC		
Баг: Могойн салбар баг- SERPENTES						
Нарийн могойн овог-Corubridae						
5	<i>Elaphe dione</i>	Рашааны могой	NE	LC		
Хорчигнуурт могойн овог - Viperidae						
6	<i>Gloydius halys</i>	Бамбай хоншоорт	NE	LC		

Тайлбар: LC- анхааралд өртөхөөргүй, NE- Үнэлгээ хийгдээгүй

Хот орчимд тохиолдох хоёр нутагтан, мөлхөгчдийн зүйлийн бүрэлдэхүүнийг авч үзэхэд ДБХХ-ны Бүс нутгийн үнэлгээгээр бүх зүйлүүд "анхааралд өртөхөөргүй" гэж үнэлэгдсэн байна.

Шувууд: Улаанбаатар хот орчимд шувуудад түшэц газар болж буй Хун нуур (шинэ авто зогсоолын дэргэдэх үүсмэл нуур), Ногоон нуур, Бөхөгийн гол, Сэлбэ

⁶ Долгорсүрэн, Г. Чагнаа, Н. 2012. Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл. Улаанбаатар.

⁷ Монгол орны хоёр нутагтан, мөлхөгчдийн улаан данс, Улаанбаатар хот, 2013 он

гол, Улиастайн гол (маш бага устай), Туул гол зэрэг ус намгархаг газрууд байна. Судалгааны талбай дахь эдгээр ус намгархаг газруудаас Туул голын шугуй, Хун нууранд шувууд олноор тааралдана. Туул голын ай савд үүсч тогтсон Хун нууранд алаг шунгаач *Bucephala clangula* (50 орчим), хондон ангир *Tadorna ferruginea* (20), зэрлэг нугас *Anas platyrhynchos* (6), хумхин бохио *Mergus merganser* (4) зэрэг шувууд олон тоогоор тааралдах ба нуурын арал үүссэн хэсэгт эгэл хараалай *Sterna hirundo* (ойролцоогоор 40-50) олноор үүрлэж, өндөгөө дарж байгаа нь ажиглагдаж байв. Эдгээр нүүдлийн шувуудаас гадна суурин шувууд Туул голын шугуй дагуу байнга тааралдана. Тухайлбал, хээрийн боршувуу *Passer montanus*, оронгийн боршувуу *Passer domesticus*, хэрээнийхэн *Corvidae* (хон *Corvus corax* болон хар *Corvus corone*, улаан хушуут жунгаа *Pyrhocorax pyrrhocorax*, алаг шаазгай *Pica pica*) түгээмэл тохиолдоно.

Мөн хот орчмын шувуудын амьдрах гол газруудын нэг нь дархан цаазат Богдхан уул бөгөөд тус уулыг 1997 онд "Дэлхийн шим мандлын дархан цаазат газрын сүлжээ"-нд хамруулсан. Хэнтийн нурууны өмнөд хэсэг болдог бөгөөд хушин ой, гацууран ой, нарсан ой, шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн өвөрмөц нөхцөл бүрдсэн байдгийг гэрчилнэ. Богдхан уулын эдгээр янз бүрийн амьдрах орчинд 14 багийн 36 овгийн 194 зүйл шувууд бүртгэгдсэн байдаг⁸.



Зураг 2-6 Хот суурин газарт түгээмэл тархсан шувууд

Хөхтөн амьтад: Хот орчмын дэвсгэр нутаг нь амьтны аймгийн газарзүйн мужлалаар умардын их мужийн Хэнтийн тойрогт багтана. Гэхдээ энд амьдрах ан амьтан, жигүүртэн шувууд нилээд онцлогтой. Учир нь хөл хөдөлгөөн ихтэй их хотын дэргэд оршин байнга амьдрах амьтад бараг үгүй болж дайжжээ. Энд зөвхөн ойн зах, хад асгат уулын ам хөндийгөөр чоно, үнэг, хярс зэрэг махан идэштэн, чандага туулай, дагуур огдой зэрэг туулай хэлбэртэн амьдарч байсан боловч их хотын чимээ шуугиан, хүн, авто хөсөг, идэш хоол, бэлчээр тэжээлийн хүрэлцээ зэргээс шалтгаалан байнга оршин амьдардаггүй болжээ⁹.

Харин урт сүүлт зурам, оготно, үхэр огодой нилээд элбэг тархжээ. Уулын ар, өвөр хажуу, ам хөндий орчмоор бялзуухай, болжмор, шаазгай, хараацай, хад цохиогоор хон хэрээ, харцага, бүргэд зэрэг шувуудтай. Эдгээр олон зүйлийн

⁸ Мягмарсүрэн, Д., Намхай, А. 2012. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. 4 дэх хэвлэл. Улаанбаатар хот, Монгол улс.

⁹ Батсайхан нар. Монгол орны хөхтөн амьтан таних гарын авалга 2014

шувууд нь ургамлын үр үндэс, хорхой шавьж, амьтны сэг сэлтийг идэж жилийн турш амьдарна. Гадны элдэв нөлөөллөөс болж шувуудын үүрлэн өндөглөх, үр төлөө бойжуулах, нуугдан хоргодох, нүүдлийн үедээ байршин амьдрах тохиромжтой тайван нутаг нь багассанаар амьдралын хэвийн зохицол алдагдах болсноос нүүдлийн шувуудын ирэх тоо ч эрс цөөрсөн байна.

Улаанбаатар хот орчмын хөхтөн амьтдын зүйлийн жагсаалтыг "Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага" (2014),¹⁰ Бүс нутгийн улаан дансны цуврал "Монгол орны хөхтөн амьтны Улаан данс" (2006) зэрэг бүтээлүүдтэй, хээрийн судалгааны мэдээллийг тулган баталгаажуулж 7 багийн 40 орчим зүйлийг гаргав. Хий дамжуулах шугам хоолой тавигдах хот орчмын бүс нутагт тархах хөхтөн амьтдын хамгааллын зэрэглэлийг Дэлхийн Байгаль Хамгаалах Холбоо (ДБХХ, IUCN)-ны шалгуур үзүүлэлтүүд, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES) болон Монгол Улсын Улаан ном (1987, 1997, 2013) зэргээр үнэлж, дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2-12 Улаанбаатар хот орчмын хөхтөн амьтаны зүйлийн жагсаалт¹¹

№	Латин нэр	Монгол нэр	Монгол улс (IUCN)	Олон улс (IUCN)	CITES	CMS
LAGOMORPHA						
1	<i>Lepus tolai</i>	Бор туулай	LC	LC		
2	<i>Ochotona dauurica</i>	Дагуур огодой	LC	LC		
3	<i>Lepus timidus</i>	Чандага туулай	LC	LC		
ERINACEOMORPHA						
4	<i>Mesechinus dauuricus</i>	Дагуур зараа	LC	LC		
RODENTIA						
5	<i>Sorex caecutiens</i>	Дааган атаахай	NE	LC		
6	<i>Sorex daphaenodon</i>	Бэсрэг атаахай	LC	LC		
7	<i>Sorex minutissimus</i>	Өөдсөн атаахай	LC	LC		
8	<i>Sorex tundrensis</i>	Цармыг атаахай	LC	LC		
RODENTIA						
9	<i>Spermophilus undulates</i>	Урт сүүлт зурам	LC	LC		
10	<i>Microtus gregalis</i>	Хэргэлзийн оготно	LC	LC		
11	<i>Pteromys volans</i>	Хөх олби	NT	LC		
12	<i>Lasiopodomys mandarinus</i>	Үлийн цагаан оготно	LC	LC		
13	<i>Alticola semicanus</i>	Хадны барагчин	LC	LC		
14	<i>Cricetulus barabensis</i>	Хөх шишүүхэй	LC	LC		
15	<i>Myodes rutilus</i>	Ойн улаан огтоно	LC	LC		
16	<i>Apodemys peninsulæ</i>	Азийн хулгана	LC	LC		
17	<i>Mys musculus</i>	Гэрийн хулгана	LC	DD		
18	<i>Allactaga sibirica</i>	Сибирь алагдаага	LC	LC		
19	<i>Myodes rufocanus</i>	Ойн хүрэн оготно	LC	LC		
20	<i>Tamas sibiricus</i>	Замба жирх	LC	LC		
21	<i>Micritus mongolicus</i>	Монгол оготно	LC	LC		
22	<i>Maemota sibirica</i>	Монгол тарвага	EN	EN		
CHIROPTERA						
23	<i>Eptesicus nilsoni</i>	Умардын сармаахай	LC	LC		
24	<i>Myotis daubentonii</i>	Усцаг багваахай	LC	LC		

¹⁰ Н. Батсайхан нар. 2014. Монгол орны хөхтөн амьтан таних гарын авлага Улаанбаатар хот, Монгол улс.

¹¹ E. L. Clark., Ж. Мөнхбат., Е.М. Monks., С. Дуламцэрэн., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., М. Stubbe 2006. Монгол орны хөхтөн амьтны улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. V Боть

25	<i>Myotis brandti</i>	Ойсог багваахай	LC	DD		
26	<i>Myotis mystacinus</i>	Сахалт багваахай	LC	LC		
27	<i>Plecotus auritus</i>	Жижиг соотон багваахай	LC	LC		
CARNIVOLA						
28	<i>Vulpes corsac</i>	Хярс үнэг	LC	NT		
29	<i>Vulpes vulpes</i>	Шар үнэг	LC	NT		
30	<i>Canis lupus</i>	Саарал чоно	LC	NT		
31	<i>Mustelo nivalis</i>	Хотын үен	LC	LC		
32	<i>Mustelo ermine</i>	Цагаан үен	LC	LC		
33	<i>Meles meles</i>	Халздай дорго	LC	LC		
34	<i>Mustela altaica</i>	Солонго үен	LC	LC		
35	<i>Mustela eversmannii</i>	Өмхий хүрэн	LC	LC		
36	<i>Otocolobus manul</i>	Мануул мий	NT	NT		
ARTIODACTYLA						
37	<i>Cervus elaphus</i>	Халиун буга	LC	CR		
38	<i>Capreolus pygargus</i>	Бор гөрөөс	LC	CL		
39	<i>Procapra gutturosa</i>	Цагаан зээр	LC	NE		

Тайлбар: LC- анхааралд өртөхөөргүй, NE- Үнэлгээ хийгдээгүй, NT-ховордож болзошгүй, CR-Устаж байгаа, EN-устаж болзошгүй, DD-мэдээлэл дутмаг


Дээрх мэдээллээс үзэхэд хот орчимд тохиолдох амьтдаас 67% нь "анхааралд өртөхөөргүй", 14% нь "мэдээлэл дутмаг", 12% нь "ховордож болзошгүй", 3% буюу 1 бодгаль "эмзэг", 5% буюу 2 бодгаль "устаж болзошгүй", 2% буюу 1 бодгаль "устаж байгаа" ангилалд тус тус үнэлэгдсэн байна. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ын II хавсралтад саарал чоно *Canis lupus*, мануул мий *Otocolobus manul* орсон байна.

2.10 ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ, ТҮҮХ СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛС

2.10.1 Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал

Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгийг зориулалтаар нь 1) Дархан цаазат газар, 2) Байгалийн цогцолборт газар, 3) Байгалийн нөөц газар болон 4) Дурсгалт газар гэж 4 ангилдаг. 2012 оны байдлаар улсын тусгай хамгаалалттай 27.2 сая га талбай бүхий 90 газар байгаагаас Дархан цаазат газар 16, Байгалийн цогцолборт газар 29, Байгалийн нөөц газар 30, Дурсгалт газар 14 тус тус байна.¹² Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал болон зориулалтыг дараах схемд харуулав.

¹² Д.Мягмарсүрэн, А.Намхай. 2012. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. Улаанбаатар хот



Схем 2-1 Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал ба зориулалт

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар гэж тухайн орон нутгийн байгалийн төрх, өвөрмөц тогтоц, түүх, соёлын дурсгал, амралт, аялал жуулчлалын ач холбогдол бүхий газар нутгийг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах зорилгоор аймаг, нийслэл, сум дүүргийн хамгаалалтад авсан газрыг хэлдэг. Орон нутгийн ТХГН нь газрын нэгдмэл сангийн ангилалаар тусгай хэрэгцээний газрын орон нутгийн тусгай хэрэгцээний газарт хамрагдах бөгөөд дотор нь засаг захиргааны нэгжээр аймаг нийслэлийн, сум дүүргийн гэж ангилна. Мөн орон нутгийн ТХГНийг хамгаалалтад хамруулсан зорилго, шинж чанараар нь:

1. Ой, амьтан, ургамал, усны нөөц газар
2. Байгаль, түүхийн дурсгалт газар гэж ангилна¹³.

Одоогийн байдлаар манай улсад орон нутгийн тусгай хамгаалалттай газрын харилцаанд шууд хамааралтай ганц журам (Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай журам), дам хамааралтай хэдэн хууль (Монгол улсын Газрын тухай хууль, Байгаль хамгаалах тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль) зэргээр зохицуулж байна. Эдгээр эрх зүйн актууд нь орон нутгийн ТХГН-ийн зорилго, шалгуур, ангилал, газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах, орон нутгийн хамгаалалтад байгаа газар нутаг дээрх газар эзэмших, ашиглах харилцааг зохицуулах, санхүүжилт зэргээс гадна энэ харилцаанд оролцож буй субъектүүдийн эрх, үүргийн хэм хэмжээ, хариуцлагын системийг тодорхойлж, зохицуулж өгдөг байна¹⁴.

2.10.2 Судалгааны бүс нутаг дахь тусгай хамгаалаттай газар нутаг

Тус Эмгэг судлалын үндэсний төв нь ТХГН болон тэдгээрийн хамгаалалт хязгаарлалтын бүсэд үл хамаарах боловч хамгийн ойр оршиж буй тусгай хамгаалалттай газар нутаг нь Богдхан уул дархан цаазат газар нутаг юм. Энэ

13 Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай журам
14

¹⁴ Газрын Харилцаа Геодези Зураг Зүйн Газар, Дэлхийн байгаль хамгаалах сан, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг газарзүйн мэдээллийн системд нэгтгэсэн тайлан, 2008 он

уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг.


2.10.2.1 Богдхан уул дархан цаазат газар

Богдхан уул нь манай орны төдийгүй дэлхийн ууган дархан газрын тоонд зүй ёсоор орно. Монголчуудын эрт дээр үеэс энэ уулыг дархан цаазтай болгон хамгаалж байсны дотор XII-XIII үед Монголын Хэрэйд аймгийн тэргүүн Ван хаан дархлан тахиж Хан уул хэмээн нэрлэсэн гэдэг. Богд уулыг 1778 онд албан ёсоор дархалсан. 1957 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 31 дүгээр тогтоолоор Чойбалсан уул нэрээр дархалж, 1974 онд Ардын их хурлын Тэргүүлэгчдийн 248-р зарлигаар Богд уул нэрээр дархан цаазат газар болгожээ. Улсын их хурлын 1995 оны 26 дугаар тогтоолоор "Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай" хуулинд нийцүүлэн дархан цаазат газрын ангиллаар баталгаажуулсан бол Байгаль орчны сайдын 2003 оны 12 дугаар сарын 25-ны 239 тоот тушаалаар дотоод бүсийн хилийн заагийг дахин шинэчлэн баталсан байна.

1997 онд Богдхан уулын дархан цаазат газар нь "Дэлхийн шим мандлын дархан газрын сүлжээ"-нд хамрагдсан байна. Энэ уул нь Хэнтийн нурууны өмнөд хэсэг, ойт хээр, хээрийн бүсийн зааг, шинэсэн ойн өмнөд хязгаар бөгөөд нийслэл орчмын нутгийн таатай уур амьсгалыг бүрдүүлэхэд онцгой нөлөө үзүүлдэг. Дархан цаазат уулын хамгийн өндөр оргил нь далайн түвшинээс дээш 2268.0 м өндөрт өргөгдсөн Цэцээгүн юм.

Богдхан ууланд эмчилгээний ач холбогдолтой хэд хэдэн рашаан булгууд бий. Зарим газар хушин ой, баруун урд ба өмнөд хэсгээр гацууран ой, баруун урд хэсгээр нарсан ой, хойд ба зүүн өмнөд хэсгээр нь шинэсэн ой зонхилон тархдаг нь тус уулын хэсэг бүрт экологийн нөхцөл өөр байдгийг гэрчилнэ. Богдхан ууланд 70 овгийн 256 төрлийн 588 зүйлийн дээд ургамал ургадаг. Ургамлын аймаг нь экологийн 18 бүлэгт хамаарах бөгөөд эдгээрээс уулын тайгын экологийн бүлгүүд 80 хувийг, хээрийн ургамлууд 72 хувийг эзэлдэг.

Хэнтийн тайгын голлох элемент болон олон зүйлийн хөхтөн амьтны тархалтын урд хил нь Богдхан уул болно. Богдхан ууланд монгол орны 6 баг, 17 овог, 36 төрөл, 54 зүйлд хамаарах хөхтөн амьтан нутагладаг байна. 174 овог, 270 гаруй төрөлд хамаарах 1660 зүйл шавж, 259 зүйлийн мезофаун, 93 микрофаун, 14 баг, 36 овогт багтах 194 зүйл шувуу бүртгэгдсэн.



Зураг 2-7 Тусгай хамгаалаттай Богдхан уул

2.11 БАЙГАЛЬ, ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

2.11.1 Хууль, эрхзүй

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 7 дугаар зүйлд "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна", Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 2-р бүлгийн 5-д эртний амьтан, ургамлын чулуужсан ясны олдвор, эртний хүний оршиж байсан үл мөрийг хадгаласан соёлт даврага бүхий оромж, отог, бууц, суурингийн үлдэгдэл, чулуун зэвсгийн бууц, суурин, дарханы газрын үлдэц, хадны зураг, бичээс, булш, хиригсүүр, бунхан, хадны оршуулга, тахилгын байгууламж, эртний хот суурин, сүм хийд, суврага, болон уран барилгын цогцолбор, дуганы үлдэгдэл, балгас, хэрэм, цайз, хийд, түүхэн дурсгалт газар, буган чулуун хөшөө, зэл чулуу, хөшөө чулуу, хүн чулуу, гэрэлт хөшөө, амьтны дүрст чулуун дурсгал, эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж байсан газар өолон газар тариалан эрхлэж байсан газар, тахилга шүтлэгтэй уул овоо зэрэг нь соёлын үл хөдлөх, биет дурсгал гэж заасан.

2.11.2 Улаанбаатар хот ормын археологийн судалгаа

Улаанбаатар хот орчмын түүх соёлын дурсгалыг археологийн талаас судлах ажил 1960 оноос эхэлжээ. 1960-1966 онд А.П. Окладников, Д. Дорж нарын удирдсан монгол зөвлөлтийн археологичдын бүрэлдэхүүнтэй Монголын чулуун зэвсгийн дурсгал судлах анги манай улсын бараг бүх аймгийн нутгийг хамарсан хайгуул судалгаа явуулж, хуучин чулуун зэвсгийн дунд, дээд үе, шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгал олон газраас олж илрүүлснээс Улаанбаатар хотын ойролцоо Сонгино уул, Буянт Ухаа, Шар хадны дэнж зэрэг газраас палеолитын үеийн хэд хэдэн бууцыг илрүүлэн олжээ. Дөрвөлжин булш, хиргисүүрийн дурсгал, хадны сүг зураг (улаан зосон, сийлмэл) нь Монголын хүрэл, түрүү төмөрлөгийн үеийн гол дурсгал юм. 1925 онд Г.И. Боровка Туул голын дунд урсгалаар археологийн хайгуул малтлага хийж 400 орчим дөрвөлжин булш олж заримыг нь малтан шинжилсэн. Мөн тэрээр Улаан хад, Их алаг, Дөрвөлжин зэрэг газраас хадны зураг, тамга нэлээдийг олж илрүүлэн анх удаа буган хөшөө, дөрвөлжин булш, хадны сүг зургийг нэгэн үед холбогдоно хэмээн үзжээ. Монгол

орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь "Сэлэнгэ"-ийн төрлийн зосон зураг юм. "Сэлэнгийн" төрлийн зосон зураг Улаанбаатар хотын дүүрэг Богд хан уулын Их тэнгэрийн ам, Гачууртын аманд байдаг. Улаанбаатараас зүүн хойш 30 км орчимд орших Гачууртын амны хаданд улаан зосоор тоймлон зурсан хүн, адуу, шувуу зэргийн зургийг илрүүлсэн байдаг¹⁵. 1960 онд А.П. Окладников, Д. Дорж нар Улаанбаатар хотын дүүрэг Их Тэнгэрийн ам зэрэг газраас хадны зургуудыг мөн илрүүлсэн байдаг байна.¹⁶

Сүүлийн жилүүдийн археологийн судалгаанаас 2013-2014 онд Я.Цэрэндагва ШУА-ийн "Эрдэм" сонинд Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал хэмээх өгүүллийг цувралаар хэвлүүлсэн ба Зайсан толгой, Маахуур толгой, Залаагийн ам, Буянт ухаа, Сонгино зэрэг хот орчмын газруудаас олдсон чулуун зэвсгийн дурсгалын талаарх тодорхойлолт, зарим зургийн хамт хэвлүүлсэн байна¹⁷.

Улаанбаатар хот орчимд буй археологийн дурсгалуудаас Гачуурт болон Их тэнгэрийн амны хадны зураг, Сонгинохайрхан ууланд орших бүлэг булш, Хэрэмт барилгын туурь зэрэг дурсгалууд улсын хамгаалалтад, Бэлхийн амны Хүннү булшнууд нийслэлийн хамгаалалтад оршдог байна.

¹⁵ Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг. // Studia Archaeologica. Tomus II. Fasc. 3-8. Улаанбаатар.

¹⁶ Дорж Д. Тэвшийн хадны зургууд. // Studia Archaeologica. Tomus IV, Fasc. 2. Улаанбаатар.

¹⁷ Я.Цэрэндагва, Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал., ШУА. "Эрдэм" сонин. УБ. 2013 №12(178), 2014М01,02(179,180)

3 БҮЛЭГ НИЙМГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Нийгэм, эдийн засгийн төлөв байдлыг тодорхойлохдоо Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн сүүлийн жилүүдэд гаргасан статистик мэдээллийг ашиглан боловсруулав.

3.1 НУТАГ ДЭВСГЭР, ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ

Нийслэлийн Сүхбаатар дүүрэг анх 1965 оны 4-р сарын 14-нд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 79-р зарлигаар "Сүхбаатарын район" нэртэй байгуулагдсан юм. Тэр үедээ 44 хороо, 19542 өрх, 96,6 мянган хvн амтай газар нутгийн хувьд томоохон район болон байгуулагдан даруй 54 жилийн нүүрийг үзэж байна. 1992 оны Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлтөөр "Сүхбаатар", "Чингэлтэй" гэсэн хоёр дүүрэг болон шинээр зохион байгуулагдсан түүхтэй.

Тус дүүрэг өнөөдөр 20.8 мянган га газар нутагтай, 20 хороо, 36165 өрхтэй, 2019 оны 5 дугаар сарын байдлаар 145335 хvн амтай, нийслэлийн томоохон дүүрэг болоод байна. Үүний хамт тус дүүрэгт нийслэлийн төр, засаг, соёл боловсрол, шинжлэх ухааны төв байгууллагууд төвлөрөн үйл ажиллагаа явуулж байдаг онцлогтой. Эдгээрийн заримаас нь дурьдвал Төрийн ордон, Ерөнхийлөгчийн болон УИХ-ын Тамгын газар, Засгийн газар, яам, агентлагууд, Нийслэлийн Төр захиргааны байгууллага, 13 улсын Элчин сайдын яам, НҮБ, Дэлхийн банк, Азийн сан, Конрад Аденауэр сангийн суурин төлөөлөгчийн газар зэрэг төрийн болон Олон улсын байгууллагууд, МАН, АН болон МАХН зэрэг улс төрийн томоохон нам, эвсэл холбоодын 30-аад байгууллага, Шинжлэх ухааны Академи, МУИС, АУИС, МУШУТИС, МУБИС зэрэг их, дээд сургууль, коллеж, УКНЭ, АҮЭ, I, II төрөх газар зэрэг томоохон эмнэлэгүүд, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж Сүхбаатар дүүрэгт байрладаг. Иймээс Сүхбаатар дүүргийг хамгийн "оюунлаг дүүрэг" гэж онцлогддог.



Зураг 0-1 Сүхбаатар дүүргийн төв байр

3.2 ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВӨЛ БАЙДАЛ

Сүхбаатар дүүрэг нь нийслэлийн төвд оршдог, тус дүүрэгт Төрийн болон ТББ, гадаадын байгууллагууд олноор төвлөрсөн, Эдмон ХХК, Мөнхийн үсэг ХХК, Чөлөөт хэвлэл сан сонины үйлдвэр, Засгийн мэдээ ХХК, ЗГХҮйлдвэр, Өдрийн сонин ХХК зэрэг хэвлэлийн томоохон үйлдвэрүүд мөн хүнсний Өгөөж ХХК,

гялгар уут үйлдвэрлэдэг Монгол хэвлэл ХХК-ниуд тус дүүрэгт байрлаж байна. Бүртгэлтэй аж ахуй нэгж 13500 гаруй үүнээс тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа нь 5200 гаруй байна. 2018 онд аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулсан, албан ёсны статистик мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжүүд 760.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2017 онтой харьцуулбал 168.2 хувиар өссөн дүнтэй ажилласан байна.

3.3 НИЙГМИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

3.3.1 Хүн ам, айл өрх

Сүхбаатар дүүргийн хэмжээнд 2019 оны 5 дүгээр сарын 01-ний албан ёсны мэдээгээр 145335 суурин хүн ам оршин сууж байна. Үүний 70010 (47.8%) нь эрэгтэй, 750325 (52.2%) эмэгтэйчүүд байна. Дүүргийн хүн амын голч нас 2010-2019 оны хооронд 28.0-28.9 байна. 2019 оны дүнгээр дүүргийн хүн амын голч нас 28.9 гарсан нь нийт хүн амын тал хувь нь 28.9-ээс доош настай, үлдсэн тал хувь нь 28.9-ээс дээш настай байгааг харуулж байна.¹⁸

Хүснэгт 0-1 Хүн амын үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 оны 5 сар	2019 оны 5 сар	Өсөлт бууралт %-иар
Өрх	Тоо	38272	38563	0.8
Хүн ам	хүн	138047	145335	5.3
Эрэгтэй	Тоо	66854	70010	4.7
Эмэгтэй	Тоо	71193	75325	5.8

Сүүлийн жилүүдэд төрөлт нэмэгдэж байгаа нь олон талын шалтгаантай. Үүнээс дурдвал Монгол улс төрөлтийг дэмжих бодлого баримталж байгаагаас гадна дүүргийн хүн амын 26.3% нь 20-34 насны залуучууд буюу ид нөхөн үржихүйн насны залуучууд байгаа нь хүн амын төрөлт нэмэгдэж, инерцээрээ өсөх болзолыг хангаж байгаа юм. Хүн амын жилийн дундаж өсөлтийн хувьд 2012 оноос эхлэн суурин хүн амаас гадаадад байгаа хүн амыг хасаж гаргадаг болсонтой холбогдуулж буурсан дүнтэй байна.

3.3.2 Хүн амын хөдөлмөр эрхлэлт

Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн захиргааны статистик мэдээгээр бүртгэлтэй, ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн тоо тайлант сарын эцэст 701 болж, өмнөх оны мөн үеэс 226(24.4%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 49.8% нь эмэгтэйчүүд бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.2 пунктээр буурчээ. Бүртгэлтэй ажилгүйчүүдийг насны бүлгээр авч үзвэл 6.3 хувь нь 15-24 насны, 40.5 хувь нь 25-34 насны, 30.5 хувь нь 35-44 насны, 18.0 хувь нь 45-54 насны, 4.7 хувь нь 55-аас дээш насны иргэд байна. Ажил идэвхтэй хайж байгаа ажилгүй иргэдийн 17 (2.4%) нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд бөгөөд үүнээс 9 (52.9%) нь эмэгтэйчүүд байна.

Хүснэгт 0-2 Дүүргийн хүн амын хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлт

¹⁸ Сүхбаатар дүүргийн эдийн засаг нийгмийн байдал, статистикийн танилцуулга 2019/IV


Үзүүлэлт	2015	2016	2017	2018
15 ба түүнээс дээш насны хүн амын тоо	91154	93165	92389	106032
Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо	50851	48862	44689	51926
-Ажиллагчдын тоо	47247	46778	40530	48255
-Ажилгүй иргэдийн тоо	3604	2084	4159	3671
-Бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо	1925	1844	1378	1153
Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо	40303	44303	47400	54105
Ажиллах хүчний оролцооны түвшин	-	52.4	48.4	49.0
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	-	50.2	43.9	45.5
Ажилгүйдлийн түвшин	-	4.3	9.3	7.1

Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулсан дүнгээр илэрхийлэгддэг ажиллах хүчний оролцооны түвшин 49.0 хувьтай байна. Ажиллах хүчний судалгааны тооцоогоор 2018 онд эдийн засгийн идэвхтэй хүн амын 48255 (92.9%) ажиллагчид, 3671 (7.1%) ажилгүй иргэд эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 7237 (16.2%) хүнээр өссөн байна.

3.3.3 Боловсрол

3.3.3.1 Сугуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсрол 2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн 33, төрийн бус өмчийн 32 цэцэрлэгт 12356 хүүхэд хүмүүжиж байгаа бөгөөд өнгөрсөн оноос 1.3%-иар өссөн дүнтэй байна. Цэцэрлэгт хүмүүжигчдын 1908 (15.4%) нь төрийн бус өмчийн цэцэрлэгт, 10448 (84.6%) нь төрийн өмчийн цэцэрлэгт байгаа ба 6138 (49.7%) эмэгтэй хүүхэд байна. Өмнөх хичээлийн жилтэй харьцуулахад төрийн өмчийн цэцэрлэг 1-ээр өссөн ба хувийн цэцэрлэгийн тоо 3-аар буурсан байна.



Зураг 0-2 Цэцэрлэгийн тоо, жил, төрлөөр

2017-2018 нийт Сургуулийн өмнөх боловсролд хамрагдагчдын 10448 (84.5%) төрийн өмч, 1908 (15.5%) төрийн бус өмчийн цэцэрлэгт хамрагдаж байна.




График 0-1 СӨБ-р хамрагдагчид, төрийн өмчөөр

Төрийн өмчийн СӨБ-д хамрагдагчдыг өмнөх онуудтай харьцуулахад 2014-2015 он 26 цэцэрлэгийн 549 хүүхэд, 2015-2016 он 32 цэцэрлэгийн 1458 хүүхэд, 2016-2017 он 32 цэцэрлэгийн 655 хүүхэд, 2017-2018 он 33 цэцэрлэгийн 169 хүүхдээр тус тус элсэгч нэмэгдсэн байна. Үүнээс харахад цэцэрлэгийн тоо нэмэгдээгүй боловч хүүхдийн тоо өссөөр байгаа нь харагдаж байна.

3.3.3.2 Ерөнхий боловсрол

Сүхбаатар дүүргийн хэмжээнд 2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн 25, төрийн бус өмчийн 22 сургуульд нийтдээ 35928 хүүхэд суралцаж байгаа бөгөөд суралцагчдын тоо өнгөрсөн оноос 1.7 хувиар өссөн байна. Нийт суралцагчдын 17796 (49.1%) эмэгтэй хүүхэд байна.

Энэ хичээлийн жилд 3928 хүүхэд шинээр 1 дүгээр ангид элсэн суралцсан бөгөөд өнгөрсөн онтой харьцуулахад 8.3%-иар өссөн үзүүлэлттэй байна. Төрийн болон төрийн бус өмчийн ерөнхий боловсролын 47 сургуульд 2945 багш ажиллагсад ажиллаж байгаа ба өмнөх онтой харьцуулахад 1.2%-иар өссөн бөгөөд нийт багш, ажиллагсдын 2273 (77.2%) эмэгтэйчүүд байна. Мөн 2014-2015 онд 1 сургуулиар, 2015-2016 онд 2 сургуулиар, 2016-2017 онд 1 сургуулиар буурч, 2017-2018 оны хичээлийн жилд 1 сургуулиар өссөн боловч 2014-2015 онд 996 суралцагч, 2015-2016 он 1998 суралцагч, 2016-2017 он 1182 суралцагч, 2017-2018 он 610 суралцагчаар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

2017-2018 нийт суралцагчдын 29020 (80.8%) төрийн өмч, 6908 (19.2%) төрийн бус өмчийн сургууль хамрагдаж байна.



График 0-2 Ерөнхий боловсролын сургуулийн үзүүлэлт

Бүлгийн тоо 2014-2015 оны 25 бүлгээр, 2015-2016 онд 43 бүлгээр, 2016-2017 онд 38 бүлгээр тус тус нэмэгдэж, нийт суралцагчдаас 2013-2014 оны 15352 (49.0%) эмэгтэй, 2014- 2015 оны 15794 (49.1%) эмэгтэй, 2015-2016 онд 16935 (49.6%) эмэгтэй, 2016-2017 оны 17548 (49.6%) эмэгтэй, 2017-2018 оны 17796 (49.0%) эмэгтэй суралцагчид эзэлж байна.




График 0-3 Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил, хүйсээр

3.3.4 Эрүүл мэнд

Дүүргийн хэмжээнд сүүлийн 5 жилийн байдлаар 17516 хүүхэд төржээ. Жилийн дундаж төрөлт 3476 бөгөөд хамгийн их нь 2014 онд 3821 эх төрсөн нь дунджаас 345 төрөлтөөр (9.9%) их, 2017 онд 3100 эх төрсөн нь дунджаас 376 төрөлтөөр (10.8%) бага үзүүлэлттэй байна. Харин сүүлийн 5 жилийн дунджаар жилд 3497 хүүхэд мэндэлсэн ба хамгийн их нь 2014 онд 3840 хүүхэд, хамгийн бага нь 2016 онд 3073 хүүхэд төрсөн нь дунджаас 424 хүүхдээр (12.1%) буурсан үзүүлэлттэй байна. Мөн жилийн дундаж нас баралт 657, хамгийн их нь 2017 онд 840, хамгийн бага нь 2016 онд 539 хүн нас баржээ.

Хүснэгт 0-3 Дүүргийн эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	Төрсөн эх	Төрсөн хүүхэд	Нас баралт	Хүүхдийн Эндэгдэл /0-1/	Эхийн эндэгдэл	Халдварт өвчин,бүгд	Бүгдээс: Цочмог халдварт өвчний гарлт
2013	3670	3695	669	41	1	1489	1008
2014	3821	3840	612	38	1	1290	781
2015	3767	3789	626	41	0	3518	2958
2016	3067	3073	539	41	2	3294	2768
2017	2763	2788	583	33	0	2335	1331
Дундаж	3476	3497	606	39	1	2385	1769

3.3.4.1 Халдварт өвчин

Дүүргийн хэмжээнд халдварт өвчин 2019 оны эхний 5 сарын байдлаар дүүргийн хэмжээнд 566 хүн цочмог халдварт, 213 хүн халдварт өвчнөөр, нийтдээ 779 хүн өвчилсөн нь өмнөх оны мөн үеэс 29 (3.9%) тохиолдлоор өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Нийт халдварт өвчний дийлэнх буюу 72.7 хувийг цочмог халдварт өвчин, 27.3 хувийг халдварт өвчин эзэлж байна.

Хүснэгт 0-4 Халдварт өвчний гаралт

Үзүүлэлт	2018 V		2019 V		Өсөлт, бууралт %
	Бодит тоо	10.0 мяг хүнд ногдох	Бодит тоо	10.0 мяг хүнд ногдох	
Бүгд	750	40.9	779	53.8	3.9
Цочмог халдварт өвчин	523	28.1	566	39.0	8.2
○ Цусан суулга	121	8.8	105	7.2	-13.2
○ Улаан эсэргэнэ	24	1.7	25	1.7	4.2
○ Улаан бурхан	-	-	-	-	-
○ Гепатит	17	1.2	4	0.3	-76.2
○ Салхин цэцэг	232	16.9	309	21.3	33.2
○ Гахайн хавдар	13	0.9	2	0.1	-84.6
○ Сальмонелёз	6	0.4	12	0.8	100.0
○ Ёлом	5	0.4	2	0.1	-60.0
○ Улаанууд	-	-	-	-	-
○ Балнад	-	-	-	-	-
○ Гар хөл гарны өвчин	102	7.4	57	3.9	-44.1
○ Хоолны хордлого	3	0.2	49	3.4	16.3
○ Бруцеллёз	-	-	1	0.1	100.0
Халдварт өвчин	227	12.8	213	14.7	-6.2
○ Тэмбүү	84	6.1	76	4.6	-9.5
○ Заг хүйтэн	39	2.8	36	2.5	-7.7
○ Шинээр илэрсэн сүрьеэ	71	5.2	66	4.6	-7.0
○ Мөөгөнцөр	-	-	-	-	-
○ Трихомониаз	33	2.4	35	2.4	6.1
○ ДОХ	-	-	-	-	-

Хүн амын дунд 10.0 мянган хүн тутмын 39 нь цочмог, 15 нь халдварт өвчнөөр өвчилж байна. Өнгөрсөн оны мөн үеэс 10.0 мянган хүн тутамд цочмог халдварт өвчнөөр өвчилсөн хүний тоо 10.9 продицимилээр, халдварт өвчнөөр өвчилсөн

хүний тоо 1.9 продицимилээр өссөн сөрөг үзүүлэлттэй байна. Нийт халдварт өвчний гаралтын нийслэлийн дүнд эзлэх хувь 8.5 байна. Цочмог халдварт өвчнөөр өвчлөгсдийн дотор хамгийн өндөр үзүүлэлттэй нь салхин цэцэг өвчин бөгөөд 309 тохиолдол гарч, 10.0 мянган хүн тутмын 21.1 нь энэ өвчнөөр өвчилж байна. Өнгөрсөн оны мөн үеэс хоолны хордлого 46 (16.3 дахин), улаан эсэргэнэ 1 (4.2%), сальмонелёз 6 (100.0%), бруцеллёз 1 (100%) тохиолдлоор өсөж, харин гар хөл амны өвчин 45 (44.1%), цусан суулга 16 (13.2%), гепатит 13 (76.5%), гахайн хавдар 11 (84.6%), ёлом 3 (60.0%), тохиолдлоор тус тус буурчээ. Халдварт өвчнөөс хамгийн өндөр үзүүлэлттэй нь салхин цэцэг өвчин бөгөөд 10.0 мянган хүн тутмын 21.1 нь энэ өвчнөөр өвчилж байгаа нь харагдаж байна.

Өнгөрсөн оны мөн үеэс сүрьеэ 5 (7.0), заг хүйтэн 3 (7.7%), тэмбүү 8 (9.5%) тохиолдлоор буурсан эерэг, трихомониаз 2 (6.1%) тохиолдлоор өссөн сөрөг үзүүлэлттэй байна.



График 0-4 Халдварт өвчний гаралт

Дүүргийн ЭМТ-өөс оны эхний 5 сард нийтдээ 289021 хүнд үзлэг хийснээс урьдчилсан сэргийлэх чиглэлээр 104168 (36.0%) хүнд, өвчний учир 113757 (39.4%) хүнд үзлэгийг хийсэн байна. Мөн хорт хавдрын 45 (12.5%), осол гэмтлийн 5 (0.7%) үзлэг хийгдсэн байна.

3.3.5 Гэмт хэрэг

Дүүргийн хэмжээнд оны эхний 5 сард цагдаагийн 1-р хэлтэст 1072, 2-р хэлтэст 531, нийт 1603 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 70 (4.2%) хэргээр буурсан эерэг үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 18.4 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 0.4 пунктээр өсжээ. Илрүүлэлт 1-р хэлтэст 18.0 хувь, 2-р хэлтэст 18.8 хувьтай байна.

Гэмт хэргийн гаралтын 66.9 хувь нь 1-р хэлтэст, 33.1 хувь нь 2-р хэлтэст гарч, өнгөрсөн оны мөн үеэс 1-р хэлтэст гарсан гэмт хэрэг 112 (9.5%) хэргээр буурсан эерэг, 2-р хэлтэст 42 (8.6%) хэргээр өссөн сөрөг дүнтэй байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн 1.2 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг, 20.0 хувийг хүний эрүүл мэнд, халдашгүй байдлын эсрэг, 0.8 хувийг хүний бэлгийн эрх

чөлөө халдашгүй байдлын эсрэг, 31.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг, 2.6 хувийг дээрэм, 24.3 хувийг залилан, 1.4 хувийг авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчсөн, 18.2 хувийг бусад гэмт хэрэг тус тус эзэлж байна.

Хүснэгт 0-5 Бүртгэгдсэн гэмт хэрэг, төрлөөр

Төрөл	Хэрэг бүртгэл			
	2018 V	2019 V	Үүнээс	
			1-р хэлтэс	2-р хэлтэс
Нийт	1673	1603	1072	531
Хүний амьд явах эрхийн эсрэг	17	19	6	13
○ Хүнийг алах	7	3	1	2
○ Хүнийг амиа хорлох нөхцөл байдал хүргэх	10	16	5	11
Хүний эрүүл мэнд халдаггүй байдлын эсрэг	349	319	222	97
Хүний бэлийн эрх чөлөө халдашгүй байдлын эсрэг	6	13	3	10
Өмчлөх эрхийн эсрэг	587	505	227	278
○ Иргэдийн өмчийн	412	436	168	268
○ Авто тээрийн хэрэгслийн	5	-	-	-
○ Халаасны	168	69	59	10
○ Малын хулга	2	-	-	-
Дээрэм	67	41	29	12
Залилан	319	390	327	63
Олон нийтийн амгалан тайдав байдал алдагдуулах	4	2	2	-
Авто тээврийн хэрэгсэл хөдөлгөөний аюулгүй байдал журам зөрчих	11	23	23	-
Бусад	313	291	233	58

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 31.5 хувийг хулгайн гэмт хэрэг эзэлж байна. Бүртгэгдсэн хулгайн гэмт хэргийн 86.3 хувийг иргэдийн өмч, 13.7 хувийг халаасны хулгайн гэмт хэрэг эзэлж байна.

Дүүргийн хэмжээнд хамгийн өндөр буюу 287 (17.9%) гэмт хэрэг 1-р хороонд, 264 (16.5%) гэмт хэрэг 8-р хороонд, хамгийн бага буюу 16 (0.9%) гэмт хэрэг 17-р хороонд тус тус бүртгэгджээ. Хулгайн гэмт хэргийн 42.2 хувь нь (1,8,11,16-р хороонд), залилангийн хэргийн 66.9 хувь нь (1,3,6,8-р хороонд) цагдаагийн 1-р хэлтсийн харьяа хотын төвийн хороодод гарч байна.

3.3.6 Хөдөө аж ахуй

2018 оны жилийн эцсийн мал тооллогоор дүнгээр дүүргийн хэмжээнд 2 аж ахуйн нэгжийн 40 толгой албаны мал, 177 өрхийн 2848 толгой амины мал, нийтдээ 2888 толгой мал тоологдсон нь өнгөрсөн оноос 163 (5.3%) толгойгоор буурсан үзүүлэлттэй байна. Үүнээс: адуу 32 (21.9%) толгойгоор, хонь 6 (1.8%) толгойгоор, ямаа 79 (20.9%) толгойгоор өсөж, харин үхэр 280 (12.8%) толгойгоор буурчээ.

Хүснэгт 0-6 Малын тоо толгой, төрлөөр

Малын төрөл	2016	2017	2018	Өсөлт бууралт %
Малын тоо бүгд	3367	3051	2888	-5.3
Адуу	142	146	178	21.9
Үхэр	2276	2188	1908	-12.8
Хонь	416	339	345	1.8
Ямаа	533	378	457	20.9
Хонин толгой шилжүүлснээр	15546	14829	13450	-9.3

3.3.7 Аж үйлдвэр

Сүхбаатар дүүрэг нь нийслэлийн төвд оршдог, тус дүүрэгт Төрийн болон ТББ, гадаадын байгууллагууд олноор төвлөрсөн, Эдмон ХХК, Мөнхийн үсэг ХХК, Чөлөөт хэвлэл сан сонины үйлдвэр, Засгийн мэдээ ХХК, ЗГХҮйлдвэр, Өдрийн сонин ХХК зэрэг хэвлэлийн томоохон үйлдвэрүүд, хүнсний Өгөөж ХХК, гялгар уут үйлдвэрлэдэг Монгол хэвлэл ХХК-ниуд тус дүүрэгт байрлаж, тогтвортой үйл ажиллагаа явуулан статистикийн идэвхтэй мэдээлэгчээр ажиллаж байна. 2018 онд аж үйлдвэрийн салбарт үйл ажиллагаа эрхлэн явуулсан, албан ёсны статистик мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжүүд 760.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь 2017 онтой харьцуулбал 168.2 хувиар өсчээ. Дүүргийн хэмжээнд аж үйлдвэрийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг, албан ёсны статистик мэдээнд хамрагдсан аж ахуйн нэгжүүд 1116.2 тэрбум төгрөгийн бүт Үйлдвэрлэлтийг салбараар нь авч үзвэл 2018 онд уул уурхайн олборлолт нийт үйлдвэрлэлтийн 93.4 хувийг эзэлж байна. Дэд салбарын үйлдвэрлэлтийг өнгөрсөн онтой харьцуулж үзвэл төмрийн хүдрийн баяжмал, махны үйлдвэрлэл 19.9-77.7 хувь өсөж, харин нүүрс, хэвлэл, арьс шир 13.5-63.2 хувиар буурсан байна.ээгдэхүүн борлуулсан нь 2017 онтой харьцуулбал 235.3%-иар өссөн байна.

4 БҮЛЭГ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛЛҮҮД

Эмгэг Судлалын Үндэсний Төвийн "Лавлага лаборатори"-н үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилсан байдлаар тодорхойлов.

4.1 ТӨСЛИЙН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛҮҮД

4.1.1 Хөрс, газрын гадаргад үзүүлж болзошгүй нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт:

- Аюултай хог хаягдлыг зориулалтын техник уруу зөөх үед зохих журмаар хийгээгүй, сав баглаа боодлын битүүмжлэл алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсгэж болзошгүй;

4.1.2 Хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй нөлөөлөл

Болзошгүй нөлөөллийн товч тодорхойлолт:

- Ажлын байрны эрүүл ахуй, аюулгүй байдлын хяналт зөрчигдөх, аюулгүй ажиллагаа, хор хөнөөлийн сургалт явуулаагүйгээс мэдлэг, туршлага багатай ажилтан эсвэл суралцагч нар гэмтэх эсвэл хордож болзошгүй;

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. CITES-ийн хавсралтанд бүртгэгдсэн амьтан, ургамлын зүйлийг таних бичиг. 2004. Улаанбаатар.
2. E. L. Clark., Ж. Мөнхбат., E.M. Monks., С. Дуламцэрэн., J.E.M. Baillie., Н. Батсайхан., Л.Я. Боркин., Р. Самъяа., М. Stubbe (Эмхэтгэгчид, редакторууд). 2006. Монгол орны хөхтөн амьтны улаан данс. Бүс нутгийн Улаан Дансны Цуврал. Боть 5. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Лондон хот.
3. Gombobaatar, S. 2009. A Dictionary of Vertebrate Animals of Mongolia. Admon print. Ulaanbaatar.
4. Terbish., Н. Munkhbayar., Н. Munkhbaatar., М. 2013. A Guide to the Amphibians and Reptiles of Mongolia (Second Edition). Admon print. Ulaanbaatar.
5. Бадамханд, Ж. 2011. Монгол орны агнуурын амьтдын лавлагаа. Хүст хэвлэл. Улаанбаатар хот.
6. Байгаль орчин ногоон хөгжлийн яам. 2014. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал (гарын авлага). Улаанбаатар хот.
7. Болдбаатар, Ш. 2008. Монгол орны шувууны фото лавлах (125 зүйл). Улаанбаатар хот.
8. Доржготов, Д. 2003. Монгол орны хөрс. Улаанбаатар хот.
9. Монголын бэлчээрийн менежментийн холбоо, 2011. Монгол орны гуурст дээд ургамлын хураангуйлсан нэрийн жагсаалт. Сэлэнгэ пресс. Улаанбаатар хот.
10. Мягмарсүрэн, Д., Намхай, А. 2012. Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгууд (4 дэх хэвлэл). Мөнхийн үсэг ХХК. Улаанбаатар хот.
11. Нямбаяр, Д., Оюунцэцэг, Б., Тунгалаг, Р. (эмхэтгэгчид). Жамсран, Ц., Санчир, Ч., Бахман, С., Сонинхишиг, Н., Гомбобаатар, С., Баиллие, Ж.Е.М., Цэндээхүү, Ц. (редакторууд) 2012. Монголын ургамлын Улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэл. Бүс нутгийн улаан дансны цуврал. Боть 10. Лондоны Амьтан Судлалын Нийгэмлэг, Монгол Улсын Их Сургууль.
12. Санжмятав, З. 2007. Монгол орны байгаль газарзүй. Улаанбаатар хот.
13. Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхтгэл. 1-р дэвтэр. 2012. Улаанбаатар хот.
14. Шийрэвдамба, Ц. (ерөнхий ред). 2013. Монгол Улсын Улаан ном. Улаанбаатар хот.
15. Эрдэнэжав, Г., Балдандорж, Г., Тусихавын, С. 1974. БНМАУ-ын бэлчээрийн тэжээлийн голлох ургамлын өнгөт альбом. Улаанбаатар хот.

16. Доржсүрэн Д., 2014. Улаанбаатар хотын усны нөөц. Улаанбаатар хот
17. Сүхбаатар дүүргийн эдийн засаг нийгмийн байдал, статистикийн танилцуулга 2019/V, Улаанбаатар хот
18. Дорж Д. Монголын хүрлийн үеийн хадны зураг. // Studia Archaeologica. Tomus II. Fasc. 3-8. Улаанбаатар.
19. Дорж Д. Тэвшийн хадны зургууд. // Studia Archaeologica. Tomus IV, Fasc. 2. Улаанбаатар.
20. Я.Цэрэндагва, Улаанбаатар хот орчмын археологийн дурсгал.,ШУА."Эрдэм" сонин. УБ. 2013 №12(178), 2014М01,02(179,180)
21. Газрын Харилцаа Геодези Зураг Зүйн Газар, Дэлхийн байгаль хамгаалах сан, Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн мэдээллийг газарзүйн мэдээллийн системд нэгтгэсэн тайлан, 2008 он
22. Мягмарсүрэн,Д. Намхай,А. Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгууд. 2012 Улаанбаатар хот
23. Долгорсүрэн, Г. Чагнаа, Н. 2012. Туул голын сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө боловсруулахад зориулсан судалгааны эмхэтгэл. Улаанбаатар.
24. Улаанбаатар хотын 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тогтоол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага. Улаанбаатар хотын өнөөгийн байдлын судалгаа дүгнэлт I бодит
25. <http://pathology-center.gov.mn/>

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

2012.08.20

/Бүртгэсэн он,сар,өдөр/

9070003081

/Улсын бүртгэлийн дугаар/

9129367

/Регистрийн дугаар/

Эмгэг судлалын үндэсний төв

Төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт
үйлдвэрийн газар

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үүсгэн байгуулах баримт бичиг/

Тушаал

/шийдвэрийн нэр/

20

/дугаар/

2005.01.28

/он,сар,өдөр/

751400

код/

Өвчтөнөөс авсан амьд сорьц, эсийн түрхэлэнд эд эсийн, химийн шинжилгээ хийж
оношлох

/Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

код/

/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/

Хугацаагүй

/хугацаа/

1

/ашигүүдийн тоо/

